



Манай хоршоо

Хөдөө аж ахуйн хоршоог удирдах нь



Сургагч багшийн гарын авлага





Манай хоршоо

Хөдөө аж ахуйн хоршоог удирдах нь

Сургагч багшийн гарын авлага

Зохиогчийн эрх © Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Олон Улсын Сургалтын Төв 2016

2016 онд монгол хэл дээр анх удаа хэвлэгдэв.

ОУХБ-ын Олон Улсын Сургалтын Төвийн хэвлэл нийтлэл нь Зохиогчийн эрхийн тухай түгээмэл конвенцийн 2 дугаар Протоколд заасны дагуу зохиогчийн эрх эдэлнэ. Гарын авлагыг хэсэгчлэн болон бүхэлд нь дахин хэвлэх буюу орчуулах эрх авах бол ОУХБ-ын Олон Улсын Сургалтын Төвд хандана уу. Гэвч эх сурвалжийг нь дурдсан тохиолдолд зөвшөөрөл авалгүйгээр иш татан ашиглаж болно.

Манай хоршоо: Хөдөө аж ахуйн хоршоог удирдах нь

ISBN: 978-92-9049-783-7

Нэгдсэн үндэстний байгууллагын практикт нийцүүлэн гаргадаг ОУХБ-ын Олон Улсын Сургалтын төвийн хэвлэл нийтлэлд Сургалтын төвийн зүгээс аливаа улс орон, бүс, газар нутгийн болон эрх барих байгууллагын эрх зүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаарыг тогтоохтой холбоотой ямарваа нэг үзэл бодол илэрхийлдэггүй болно.

Зохиогчтой өгүүлэл, судалгаа болон бусад нийтлэлд илэрхийлэгдсэн үзэл бодлын талаарх хариуцлагыг гагцхүү тэдгээрийг зохиогч хүлээх бөгөөд Олон улсын хөдөлмөрийн товчоо хэвлэн нийтэлсэн нь тэдгээрт илэрхийлсэн үзэл бодлыг зөвшөөрсөн хэрэг биш юм. Фирмийн нэр болон арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцын талаар дурдсан нь Сургалтын төвийн зүгээс тэдгээрийг сайшааж байгааг илэрхийлэхгүй бөгөөд тодорхой фирм, арилжааны зориулалттай бүтээгдэхүүн, технологийн үйл явцыг дурдалгүй орхигдуулсан бол энэ нь тэдгээрийг үгүйсгэсэн явдал биш болно.

Сургалтын төвийн хэвлэл нийтлэл, каталоги, шинэ бүтээлийн жагсаалтыг дараах хаягаар авч болно.

Publications, International Training Centre of the ILO

Viale Maestri del Lavoro, 10 - 10127 Turin, Italy

Telephone: +39 011 6936693

Fax: +39 011 6936352

E-mail: Publications@itcilo.org

Монгол гэрэл зургийг © Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний Холбоо

Хэвлэлийн эхийг ОУХБ-ын Олон Улсын Сургалтын Төвийн загвараар бэлтгэж Монгол улсад хэвлэв.

Гарчиг

Талархал	v
Товчилсон үгс	ix
Нэр томъёоны тайлбар.....	x
Товч агуулга	1
Сургагч багшийн гарын авлагын тухай.....	7

Сургалтын үйл ажиллагаа..... 11

1.0: “Манай хоршоо” нийгмийн бүлгийн судалгаа.....	13
--	----

Модуль 1:

ХАА-н хоршооны тухай үндсэн ойлголт 15

1.1: Хоршооллын шоо Хоршооны тухай үндсэн ойлголт ба зарчмуудын танилцуулга.....	15
1.2: Хоршооны гишүүн болох нь Хоршооны мэдлэгийн өртөө. Дугуй ширээний албан бус сургалт	18
1.3: Хоршоогоо товч танилцуулъя. Бодит түүх ярих дасгал ажил	20
1.4: Хоршооны хүрээлэн буй орчин. Хамтын ажиллагааны шинжилгээ	23
1.5: Өртгийн сүлжээний дасгал ажил.	27
1.6: Засаглалын сорилтууд. Оюуны бичиглэлийн дасгал ажил.	30

Модуль 2:

Хоршооны үзүүлэх үйлчилгээ 31

2.1: Хэрэгцээг тодорхойлох. Ялгаатай арга хэрэгслүүдийн эвлүүлгийн дасгал ажил.....	31
2.2: Оюуны зураглал ба хэрэгцээг эрэмбэлж үйлчилгээтэй холбох дасгал ажил.....	33
2.3: Нөхцөл байдлын шинжилгээ - Давуу ба сул тал, боломж, аюул Хоршоо гишүүддээ үйлчилгээ үзүүлэхийн тулд чадавхиа хэрхэн сайжруулах вэ.....	35

Модуль 3:

ХАА-н үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт 37

3.1: Бие биедээ туслах арга ашиглан тодорхой сорилтуудыг шийдвэрлэх..... 37

3.2: Хадгалалт ба агуулахын удирдлагын “Өртөөчилсан аялал” дасгал ажил 39

3.3: Үнийн бодлого боловсруулах. Шинжээч нарын мэтгэлцээний
дасгал ажил 41

Модуль 4:

Хоршооны маркетинг 43

4.1: Өртгийн сүлжээний бодит жишээ 43

4.2: Зах зээлийн мэдээлэл: Хоршооны шинжилгээ 45

4.3: Үйл ажиллагааг сайжруулах. Шилдэг 100 жагсаалт 47

4.4: Маркетингийн хольцын хөлөгт тоглоом. 49

4.5: Баталгаажуулалтын тогтолцоон дахь Давхар тойргийн дасгал ажил 51

Бүх модулиуд..... 53

5.1: “Чөлөөт орон зай” 53

5.2: Туршлага судлах аялал 56

5.3: “ХАА-н хоршоог удирдах нь” сургалтыг үнэлэх дасгал ажил 57

Ном зүй. 58

Хавсралт 1. Сургалтын төлөвлөгөөний загвар. 59

Хавсралт 2. Маркетингийн хольцын хөлөгт тоглоом. 60

Талархал

Зохицуулагч

Карлиен ван Эмпел ОУХБ-ын "Африкийн хоршооллын төлөө" хөтөлбөр

Редактор

Карлиен ван Эмпел ОУХБ-ын "Африкийн хоршооллын төлөө" хөтөлбөр

Зохиогч

Том Вамбеке ОУХБ/ОУСТ "ДЕЛТА" хөтөлбөр

Хэл найруулгыг:

Редакторын баг "Жулиет Хайдок транслэйшнз" ХХК

Энэ материалд санал, шүүмж өгч туслалцаа үзүүлсэн Наргиз Кишиева, Анна Лавен, Эллен Мангнус, Ремко Мур, Хусейн Полат, Карлиен ван Эмпел болон Нигер улсад зохион байгуулсан туршилтын сургалтанд оролцогчид, бусад зохион байгуулагч нартаа талархалаа илэрхийлье.

Энэхүү сургалтын материалыг дараах байгууллагууд боловсруулав:



Агритерра нь Голланд улсын хөдөөгийн иргэдийн байгууллагууд хамтран байгуулсан, олон улсын хамтын ажиллагааны байгууллага юм. Агритерра нь хөгжиж буй орнуудын хөдөөгийн иргэдийн байгууллагуудыг хүчирхэг төлөөллийн байгууллага болоход санхүүгийн туслалцаа шууд үзүүлэх, өрхийн хэмжээний ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн харилцан туслалцааг дэмжих зэрэг олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Хөдөөгийн иргэдийн байгууллагууд нь хөгжиж буй орнуудад ардчиллыг хөгжүүлэх, орлогын жигд хуваарилалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийг хөгжүүлэхэд нэн чухал үүрэгтэй. Хэрэв малчид, тариаланчид хоорондоо нэгдэж, үйлдвэрлэлээ уялдаатай явуулж, зах зээлд эзлэх байр сууриа дээшлүүлбэл орлогоо нэмэгдүүлж, ажлын байр бий болгох зэргээр амжилтанд хүрэх боломжтой. Агритерра нь Голланд улсын болон хөгжиж буй орнуудын хөдөөгийн иргэдийн байгууллагын эдийн засгийн үйл ажиллагааг дэмжиж, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, дэмжих, санхүүжүүлэх зорилготой ажилладаг.

<http://www.agriterra.org>



Неймеген хотын Олон улсын хөгжлийн судалгааны төв (НХОУХСТ) нь тэгш бус байдал, ядуурлыг бууруулах, хөгжлийг дэмжих, чадавхи бэхжүүлэх зорилготой олон салбарыг хамарсан боловсрол, судалгааны институт юм. Тус байгууллага хөгжлийн судалгаагаар бакалавр, магистр, докторын зэргийн боловсрол олгохын зэрэгцээ хөгжил, эдийн засаг, социологи, хүн судлал зэрэг чиглэлээр эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэдэг. НХОУХСТ нь хөдөөгийн хөгжил, өртгийн сүлжээ, бараа түүхий эдийн бэлтгэл, зах зээлийн интеграци, өртгийн сүлжээний дүрэм, журам, стандартын улмаас бий болох нөлөөллийн үнэлгээ, жендерийн онол, бодлого, асуудлыг олон нийтийн анхааралд оруулах чиглэлээр олон салбарыг хамарсан судалгаа хийдэг арвин туршлагатай.

<http://www.ru.nl/cidin>



Кени улсын Хоршооллын коллеж (КУХК) нь Найроби хотын төвөөс 17 км-т байгалийн сайханд оршдог. 1952 онд тус улсын хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавих засгийн газрын байцаагчдыг сургах зорилгоор байгуулагдсан бөгөөд цаашид их сургууль болох зорилттой ажиллаж байна. Тус байгууллага хоршооллын хөдөлгөөнийхөн ба тэдний эдийн засгийн түншлэгчдэд удирдлага, хяналтын зохих үр чадвар олгож, хоршооллын хөгжилд илүү хувь нэмэр оруулахад нь туслах зорилготой. Хоршооны менежмент, банкны үйлчилгээний чиглэлээр дипломын зэрэг, сертификат олгох сургалт, хоршооны ажилтан, удирдлагуудад зориулан богино хугацааны сургалт зохион байгуулдаг. Тус коллеж ISO 9001:2008 стандартын батламж авсан.

<http://www.cooperative.ac.ke>



"Африкийн хоршооллын төлөө" хөтөлбөр (КООП_{африк}) нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хоршооллын хөгжлийг дэмжих зорилготой бүс нутгийн техникийн хамтын ажиллагааны хөтөлбөр юм. Энэ нь олон улсын ба үндэсний олон байгууллагыг хамарсан түншлэлийн санаачлага бөгөөд бодлого, хууль, эрх зүйн таатай орчин, хоршооллын хүчирхэг босоо тогтолцоо, засаглал, үр шим, үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг. Тус хөтөлбөрийг Танзани улс дахь ОУХБ-ын салбараас удирдан зүүн өмнөд Африкийн 9 орон (Ботсвана, Этиоп, Кени, Лесото, Руанда, Суазиланд, Танзанийн эх газар ба арлууд, Уганда, Замби улс)-д хэрэгжүүлж, Женев хот дахь ОУХБ-ын Хоршооллын хөтөлбөрөөс (ЭМП/КООП) техникийн туслалцаа үзүүлдэг. Анх 2007 оны 10-р сард Их Британийн Олон улсын хөгжлийн яамны (ОУХЯ) санхүүжилтээр хэрэгжүүлж эхэлсэн.

<http://www.ilo.org/coopafrica>



Жижиг аж ахуй эрхлэгч малчид, тариаланчдыг зах зээлд гарахад дэмжлэг үзүүлэх (ЖААЭМТЗЗГДҮ) түншлэл нь нийт 11 орны малчид, тариаланчдын үндэсний байгууллага ба АГРИНАТУРА-гийн хоорондын түншлэл юм. Бодлого, хууль эрх зүйн таатай орчин бий болгож, эдийн засгийн хувьд үр дүнтэй ажилладаг байгууллага, институтууд байгуулах замаар хөгжиж буй орнуудын өрхийн аж ахуй эрхэлдэг малчид, тариаланчдын бэлэн мөнгөний орлого олох чадавхийг сайжруулах зорилготой бөгөөд малчид, тариаланчдын байгууллагуудаас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээг дэмжиж, эрэлтэнд суурилсан судалгаа явуулдаг.

<http://www.esfim.org>



Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ) нь Нэгдсэн үндэстний байгууллагын салбар байгууллага бөгөөд гишүүн орнуудынхаа засгийн газар, ажил олгогч, ажилчдын гурван талт хамтын ажиллагаа бий болгож, зохистой ажлын байрыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэн ажилладаг. ОУХБ нь дэлхий даяар эмэгтэй, эрэгтэй бүх хүмүүсийн амьдрах, ажиллах нөхцлийг сайжруулахад хоршоолол чухал үүрэгтэй гэж үздэг. Тус байгууллагын Хоршооллын хөтөлбөр (ЭМП/КООП) нь Хоршооллыг дэмжих тухай ОУХБ-ын 2002 оны 193 дугаар зөвлөмжийн дагуу ОУХБ-ын бүрэлдэхүүн байгууллагууд ба хоршоодод үйлчилдэг. Мөн Олон улсын хоршооллын холбоотой (ОУХХ) хамтран ажиллаж, Хоршооллыг сайшаан дэмжиж, цаашид хөгжүүлэх хорооны (ХСДЦХ/КОПАК) бүрэлдэхүүнд ажилладаг.

<http://www.ilo.org> ба <http://www.ilo.org/coop>



ОУХБ-ын Олон улсын сургалтын төв нь ОУХБ-ын сургалтын байгууллага бөгөөд тус төвийн “зайны сургалт” ба “суралцах арга, технологи” (ДЕЛЬТА) хөтөлбөр нь туршлагад суурилсан сургалтын арга зүйг нэвтрүүлэх зорилгоор өөрийн дотоод чадавхийг сайжруулах, гадны түншлэгч байгууллага, хэрэглэгчдэд сургалт зохион байгуулах үүрэгтэй. Ингэхдээ ОУХБ-ын Хүний хөгжлийн тухай 195 дугаар зөвлөмжийн дагуу ажилладаг. Тус төвийн аж ахуй, бичил санхүүгийн байгууллага, орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нь хоршоо ба нийгэм, эдийн засгийн хамтын үйл ажиллагаа эрхэлдэг бусад байгууллагад зориулж аж ахуй эрхлэгчдэд боловсрол олгох, жижиг аж ахуйн тогтвортой хөгжлийн бизнес орчинг бүрдүүлэх, өртгийн сүлжээ, бизнесийн хөгжлийн үйлчилгээ болон аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зэрэг олон төрлийн сургалт зохион байгуулдаг.

<http://www.itcilo.org>



Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага нь өлсгөлөнг таслан зогсоох чиглэлээр олон улсын хэмжээнд тэргүүлэгч байгууллага юм. Хөгжингүй болон хөгжиж буй бүх улс оронд хүрч ажилладаг. ХХААБ нь гэрээ хэлэлцээр хийх, бодлого хэлэлцэхэд бүх үндэстний эрх тэгш байдлыг хангах үүрэгтэй, төвийг сахисан байр суурьтай. Уг байгууллага хүн төрөлхтнийг хүнс тэжээлээр бүрэн хангахад анхаарч, ХАА, ой мод, загас агнуурын аж ахуйг сайжруулах, хөгжиж буй болон хөгжингүй улсуудад туслах, мэдээлэл, мэдлэгийн эх сурвалж нь болдог. НҮБ-ын ХХААБ нь 1945 онд анх байгуулагдсан цагаасаа өлсгөлөн нүүрлэж, ядуу хүмүүсийн 70 хувь нь амьдран суудаг хөгжиж буй хөдөө нутагт гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

<http://www.fao.org>



Кени улсын ХАА-н үйлдвэрлэгчдийн үндэсний холбоо нь 1946 онд ашгийн бус, улс төрөөс ангид, ардчилсан гишүүнчлэл бүхий Кени улсын ХАА-н үйлдвэрлэл эрхлэгчдийн үндэсний холбоо (КУХААҮЭҮХ) нэрээр бүртгэгдсэн байгууллага. Энэ байгууллага малчид, тариаланчид амьжиргаагаа тогтвортой сайжруулахын тулд хүчтэй дуу хоолойгоо нэгтгэж, зөв мэдээлэлд суурилсан сонголт хийхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Өөрөөр хэлбэл малчид, тариаланчдын хууль ёсны дуу хоолой болохынхоо хувьд гишүүддээ болон ХАА-д бүхэлд нь онцгой нөлөө үзүүлж буй асуудлуудыг тодорхойлох үүрэгтэй. Тус холбоо гишүүддээ төлөөллийн болон лобби үйл ажиллагаа явуулж, өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг. Түүнчлэн олон улсын, бүс нутгийн ба үндэсний түвшинд гишүүд хоорондын дунд хамтын ажиллагаа, сүлжээг дэмжиж ажилладаг. Мөн гишүүдийнхээ эрх ашгийн төлөө судалгаа хийж, зөвлөх үйлчилгээг үзүүлдэг.

<http://www.kenfap.org>



Моши хотын Хоршоо, бизнесийн судалгааны их сургууль (МХХБСИС) нь Танзани улсад хоршооны нягтлан бодох бүртгэл, менежмент, хөдөөгийн хөгжлийн чиглэлээр хамгийн удаан буюу 48 жил ажилласан хоршооны сургалтын институт. 2004 оны 5 сард хуучин Хоршооны коллежийг өргөжүүлж МХХБСИС-ийг Сокоиний нэрэмжит Хөдөө аж ахуйн их сургуулийн (СНХААИС) салбар коллеж болгосон. Хоршоо ба бизнесийн боловсролыг бакалавр, магистрын түвшинд олгодог. Тус сургууль сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээгээрээ дамжуулан хоршоод, хүн ард, бизнесийн байгууллага, хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих, хөгжүүлэх, мэдлэг, ур чадвар олгох, сурталчилах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

<http://www.muccobs.ac.tz>



Нигер улсын Хоршооны хөгжлийн төв (НУХХТ) нь Абуха-локохагийн хурдны замын 61 дүгээр тэмдэгтэд байрладаг. Хотын төвөөс зайтай, 14 га талбайг эзлэн оршиж, эрдэм шинжилгээ, сургалтын тааламжтай орчныг бүрдүүлсэн. Тус төв нь Холбооны улсын хоршооллын яам болон хоршооллын хөдөлгөөнийг дэмжигч бүхий л байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгдөг. Ингэхдээ хоршооны талаарх бодлого, хууль тогтоомж, сургалтын чиглэлээр судалгааны ажил хийх, шилдэг туршлагаудыг нэвтрүүлж ажилладаг. Мөн хоршооллын салбарыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг дэмжиж, хоршооны тэргүүлэгчид, хяналтын зөвлөлийн гишүүд, сургагч багш нарыг сургаж, хоршооны мэдээллийн сан бий болгож, дүн шинжилгээ хийдэг.



Royal Tropical Institute

“Роял Тропикал” институт (РТИ) нь Амстердам хотын олон улсын соёлын өвийн тухай мэдлэг, туршлагыг цуглуулдаг, олон улсын хамтын ажиллагааны бие даасан төв. Тус төв тогтвортой хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах, соёлын өвийг хамгаалах, соёлын солилцоог дэлгэрүүлэх зорилготой. Голланд улс эдгээр асуудалд анхаарлаа хандуулж, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлдэг. Иймд тус төв нь дээрх чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа явуулж, зөвлөх ба мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг. Тэдний үйл ажиллагааны үндсэн чиглэл нь бодит амьдралын туршлагыг бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд тусгадаг явдал. Тус институт соёлын өвийг хамгаалж, үзэсгэлэн зэрэг арга хэмжээ зохион байгуулж, уулзалт, мэтгэлцээн зохион байгуулахад байр, танхимаар хангадаг. Өөр өөр соёлын хувьд хуримтлагдсан мэдлэг, ойлголтыг сайжруулах ба харилцан солилцох үндсэн зорилготой. “РТИ нь Голланд улсаас гадаадын түншүүдтэйгээ хамтын ажиллагаа өрнүүлэхэд төр, хувийн хэвшлийн аль алиных нь төлөө ажилладаг төрийн бус байгууллага юм” (эрхэм зорилго).

<http://www.kit.nl>



UGANDA COOPERATIVE ALLIANCE LTD

Уганда Улсын Хоршоодын холбоо (УУХХ) нь тус улсын хоршооллын байгууллагуудын малгай байгууллага. 1961 онд Уганда улсын хоршоодын эдийн засаг, нийгмийн эрх ашгийг хамгаалах зорилгоор байгуулагдсан. Тус оронд бүх төрлийн хоршоог (анхан шатны хоршоо, мужийн ба үндэсний холбоо) дэмжиж зөвлөгөө үзүүлэх, чадавхи бэхжүүлэх зорилгоор байгуулагдсан. УУХХ нь 6 чиглэлд төвлөрч үйл ажиллагаагаа явуулдаг. Үүнд: анхан шатны бүлгүүд, хоршоодын чадавхийг бэхжүүлэх, гишүүдийн хадгаламжинд суурилан хоршооны санхүүгийн системийг бэхжүүлэх, технологийн шинэчлэл хийх, эмэгтэйчүүдийг хүчтэй болгох, залуусын хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ба байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх.

<http://www.uca.co.ug>



Вагенинген хотын Их сургууль, эрдэм шинжилгээний төв (ВХИСЭШТ) нь хүмүүсийн амьдралын түвшинг дээшлүүлэх зорилгоор байгалийн боломж, бололцоог нээн илрүүлдэг. Тус сургууль дэлхийн 100 гаруй орны засгийн газар, томоохон бизнесийн

байгууллагад хүн амын эрүүл хүнс, амьдрах орчны асуудлыг хариуцаж ажиллах 10,000 оюутан сургадаг, 6,500 гаруй ажилтантай томоохон их сургууль. Тус сургуулийн дэргэдэх Хөгжлийн төлөөх инновацийн төв (ХТИТ) нь өөрчлөлт хийх чадавхи бий болгохын төлөө ажилладаг бөгөөд хүнсний үйлдвэрлэлийн тогтолцоо, хөдөөгийн хөгжил, агро бизнес, байгалийн нөөцийн менежмент зэрэг чиглэлд төвлөрч, инновацийг хөгжүүлэн мэдлэг түгээж, чадавхи бэхжүүлдэг. Тус төв Вагенингений их сургууль, эрдэм шинжилгээний төвийн нээн илрүүлсэн мэдлэг туршлагыг сургалт, инновацийн нийгмийг бүхэлд нь хамарсан үйл явцтай холбож өгдөг.

<http://www.wur.nl/UK> ба <http://www.cdi.wur.nl/UK>

Товчилсон үгс

ОУХБ Олон улсын хөдөлмөрийн байгууллага

ОУХХ Олон улсын хоршооллын холбоо

ТББ Төрийн бус байгууллага

НБШ Нөхцөл байдлын шинжилгээ

Оюуны довтолгоо буюу санаа цуглуулах	Идэвхтэй, чөлөөт бүлгийн хэлэлцүүлгийн явцад бүтээлч санаа болон шийдлийг гаргах үйл явц юм. Хэлэлцүүлэгт оролцогч бүрийг маш идэвхтэйгээр оролцож аль болох олон санаа бодож олохыг даалгадаг бөгөөд гарсан санаануудын дүгнэлт, хэлэлцүүлэг, шүүмжлэл зэргийг санаа цуглуулах үе дууссаны дараа, үнэлгээний үе эхлэхэд хэлэлцдэг.
Оюуны зураглал	Буруу зөвийг ялган эргэцүүлэх, хувь хүний зөрчилдөөн, өгөгдсөн хугацаанд нэг нэгээрээ өөрийгөө илэрхийлэх зэрэг сорилтуудыг оюуны довтолгоо хийж гүйцэтгэх энгийн арга техник юм.
Бичил бүлэг	Маш богино хугацаанд тодорхой нэг сэдвээр ярилцах 2-3 оролцогчидтой, төлөвлөлтгүйгээр шууд бүрдүүлсэн жижиг бүлэг юм.
Баталгаажуулалт	Хандлага, үзүүлэлт, чанар, чадвар, хувь хүн болон байгууллагын байр суурь, бараа үйлчилгээ, дүрэм журам, үйл явц, нөхцөл байдал, үйл явдал зэргийг итгэмжлэгдсэн буюу эрх бүхий хүн, албан байгууллагаас тогтсон шалгуур, стандартад нийцсэн эсэхийг үнэлж шалгаж хянаад баталгаа бичиж өгдөг албан ёсны үйл ажиллагаа юм. Эх сурвалж: http://www.businessdictionary.com/definition/certification.html (2011.10.19)
ХАА-н үйлдвэрлэлийн орц	ХАА-н үйлдвэрлэлд ашиглагддаг химийн бодис, тоног төхөөрөмж, үр, бордоо, тэжээл, эрчим хүч, бусад зүйлсүүд гэх мэт Эх сурвалж: http://www.websters-online-dictionary.org/definitions/Farm+inputs (2011.10.22)
Давхар тойргийн арга	Энэ аргыг олон хүнтэй бүлгийн хэлэлцүүлэгт ашиглахад илүү тохиромжтой. Давхар тойргийн хэлэлцүүлэгт дотор талын жижиг тойрогт сууж харилцан ярилцаж байгаа жижиг бүлэг, тэдний тойргийн гадуур тойрч суусан олон хүнтэй том тойрог бүхий ажиглагчдын бүлэг багтдаг. Чиглүүлэгч эсвэл багш хэлэлцүүлгийн ерөнхий зарчмыг товч танилцуулсны дараа дотор талын тойргийнхон хэлэлцүүлгээ эхэлнэ. Гадна талын тойргийнхон хэлэлцүүлгийн явцыг ажиглаж сонсоно. Хэрвээ гадна тойргийн ажиглагч дотор тойрог руу орохыг хүсвэл дотор тойргоос нэг оролцогч сандлыг чөлөөлж гадна тойрог гуу шилжих шаардлагатай болно. Эх сурвалж: http://itcilo.wordpress.com/2009/02/16/facilitate-a-fishbowl-discussion.html (2011.10.22).
Албан ёсны судалгаа	Шаардлагатай тохиолдолд статистик дүгнэлт болж чадах мэдээллийг олж авахад ашиглагддаг судалгааны хэрэгсэл юм. Албан ёсны асуулга нь тодорхой нарийн бүтэцтэй /асуултуудын жагсаалт/ асуултуудаас бүтэх бөгөөд олон тооны тийм, үгүй асуултаас бүрдсэн, үр дүнг нь тооцож болохуйц байдаг. Эх сурвалж: http://www.websters-online-dictionary.org
Албан бус судалгаа	Албан бус судалгаа нь ярилцлага хэлбэртэй бөгөөд мэдээлэл нь албан судалгаатай харьцуулахад дэс дараалал муутай байдаг ба судалгааны статистик үндэслэлд анхаарахаасаа илүүтэй хэлэлцүүлэг, ярилцлагадаа ач холбогдол өгдөг. Энэхүү хэлэлцүүлэг, харилцан ярианаас тодорхой ойлголт авахад хялбар байдаг.
Маркетинг	Маркетингийн ойлголтонд хэрэгцээ болон зах зээлээ тодорхойлох, барааг хадгалах, сурталчилгаа гэх мэт бүтээгдэхүүн борлуулахтай холбоотой бүх асуудлууд багтана.

Оюуны зураглал	Оролцогчид өөрсдийн бодлын агуулга болон бүтцийг тодорхой үйл явц ашиглан гаргах сургалтын арга юм. Оролцогчид өөр өөрсдийн бодлын зураглалыг зурсны дараа жижиг бүлгээр нэгдэн ажиллаж бүх оролцогчдын саналыг оролцуулсан урьдчилсан төлөвлөлтийн том зураглал хийдэг. Энэ арга нь оролцогч бүрт өөрийн бодлоо гаргах боломж өгдөг ба гарсан бүх санаануудаа хуваалцдаг. Хамтарсан хэлэлцүүлгээс гарсан санаанууд нь бүлгийн бодлын дүр зургийг гаргахад ашигтай дасгал болдог. Түүнчлэн энэ арга ойлголтуудын хоорондын харилцаа хамаарлыг гаргахад оролцогчдод сэдэл өгдөг.
Эх сурвалж: http://itcilo.wordpress.com/2009/03/02/map-your-mind/ (2011.10.22).	
Зохион байгуулалтын схем	Оролцогчдын мэдлэгийн түвшний ялгаатай байдал, тэдгээрийн хоорондын харилцаа, бүтэц, зохион байгуулалтыг харуулсан схем.
Үнэ тогтоолт	Бараа бүтээгдэхүүнээ зарж борлуулах үнэ тогтоох арга. Ихэнх тохиолдолд үнийг дундаж зардал болон хэрэглэгчийн хүсэн хүлээсэн бүтээгдэхүүний үнэ цэнийг өрсөлдөгч бүтээгдэхүүний чанартай харьцуулсан харьцаанаас хамааран тогтоодог.
Эх сурвалж: http://www.businessdictionary.com/definition/pricing.html (2011.10.22).	
Өртөөчилсөн аялал	Жижиг бүлэг доторх харилцан үйлчлэлийн ээлж дарааг бүрдүүлдэг харилцааны арга. Энэ нь хичээлийн сэдэвтэй маш амархан зохицож холбогддог бөгөөд "Дэлхийн мэдлэгийн өртөө" (олон хүнтэй бүлэг тодорхой нэг сэдвээр хэлэлцүүлэг хийх) аргатай адил боловч шинжээч удирдаж явуулдагаараа ялгаатай.
Эх сурвалж: H:\GP-DELTA\Toolkit\Methodologies\Instructionalfiches	
Хадгалалт	Агуулахын үйл ажиллагаатай холбоотой бүх үйл явц хамаарах бөгөөд гишүүдийнхээ хэрэгцээг хангахын тулд хадгалалтын зөв горимд хадгалсан барааг гаргана.
Туршлагаа хуваалцах	Мэдээллийг сонирхолтой, холбоотой аргаар дамжуулдаг харилцааны хэрэгсэл юм. Олон хүний анхаарлыг татахуйц, сурах эрмэлзлийг төрүүлсэн, ярианы хэлбэр бөгөөд хэл нь (баримтад биш туршлагад тулгуурласан) ойлгомжтой байх ёстой юм.
Нөхцөл байдлын шинжилгээ	Давуу ба сул тал, боломж, аюул гэсэн нөхцөл байдлын шинжилгээг үнэлж гаргахад зориулсан хэрэгсэл. Нөхцөл байдлын шинжилгээг өрхийн төдийгүй том фермерийн аж ахуй болон бусад бүх төрлийн бизнесийн байгууллагад хийж болдог. Энэ шинжилгээ нь өнгөрсөндөө дүгнэлт хийх,одоо явуулж буй үйл ажиллагаандаа болон шинээр эхлэх бизнест тулгарч болзошгүй асуудлуудыг шийдвэрлэх боломжит гарцыг хайхад тусалдаг.
Эх сурвалж: http://farm-risk-plans.usda.gov/pdf/swot_brochure_web.pdf (2011.10.22).	
Ахиц дэвшил	Хоршоод, малчид үйл ажиллагааны үр өгөөжөө нэмэгдүүлэх боломжит нөхцөлүүдийн тухай ойлголт юм.
Эх сурвалж: http://www.kit.nl/net/KIT_Publicates_output/ShowFile2.aspx?e=1687	
Өртгийн сүлжээ	Бүтээгдэхүүн (бараа, үйлчилгээ)-ийг үйлдвэрлэх, боловсруулах, тээвэрлэх зэрэг үе шатаар дамжуулан эцсийн хэрэглэгчид хүргэх дэс дараалсан цуврал алхмууд юм. Эдгээр алхам бүрт бүтээгдэхүүнд үнэ цэнэ нэмэгдэж байдаг.



Товч агуулга

ХАА-н хоршооны удирдлагын тухай тус сургалтын багц ямар ач холбогдолтой вэ?

ХАА-н салбар бол “Малчид, тариаланчид дэлхийг хүнсээр хангадаг” гэсэн утгаараа дэлхийн хөгжилд хамгийн чухал салбар. Мөн дэлхий дахинаа ажлын байр бий болгож байгаа 2 дахь том салбар юм.¹

Олон орны хувьд ХАА-н салбар хөгжлийнх нь гол түлхүүр болсон тухай түүхэнд олонтаа өгүүлсэн байдаг. Орчин үед дэлхий дахинаа хоршоод нь мэдээллийн агентлаг, сургууль, “ногоон эрчим хүч” нийлүүлэгч зэрэг шинэ салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч ХАА нь хоршооллын бие даасан, тогтвортой салбар хэвээр байна.

Энэхүү багц гарын авлагыг “Хүчирхэг бөгөөд төлөөллийг хангасан хөдөө аж ахуйн байгууллагууд нь аливаа улс оронд ардчиллыг хөгжүүлэх, орлогыг тэгш хуваарилах, эдийн засгийг хөгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй байдаг”² гэсэн итгэл үнэмшилд суурилан боловсруулж гаргалаа. Аргентин, Этиоп, Франц, Энэтхэг, Голланд, Шинэ Зеланд, Америкийн нэгдсэн улс зэрэг ХАА-н салбар чухал байр суурь эзэлдэг орнуудад хөдөө аж ахуйн хоршоод нь хүчирхэг байдгийг баримт нотолгоо харуулж байна.³

Гэхдээ ХАА-н хоршоонд гадаад, дотоод олон хүчин зүйл нөлөөлж байдаг. Гадаад хүчин зүйлд зах зээл, хууль дүрэм, дэд бүтцийн хөгжил, уур

амьсгалын өөрчлөлт ордог. Дотоод хүчин зүйлд хоршооны засаглал, менежементийн асуудал багтдаг.

Хоршоо хэмээх аж ахуйн нэгжийн эн тэргүүний зорилт бол ашиг олох явдал биш, харин гишүүдийнхээ эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхлыг хангах явдал юм. Хоршооны гишүүд хувь нийлүүлсэн хөрөнгөөрөө дамжуулан хоршоогоо өмчилж, ардчилсан зарчмаар хяналт тавьж, хоршооноосоо үйлчилгээ авдаг. Ингэснээр хоршоогоо уян хатан шинж чанартай, иж бүрэн, хүч чадал сорьсон бизнесийн загвар болгодог. Хоршооны гишүүдийнхээ эрх ашиг, бизнесийн боломж, нийгмийн хариуцлага гэсэн асуудлууд нь хоорондоо зөрчилдөхөд хүрдэг.

“Манай хоршоо” сургалтын багц юун тухай танилцуулах вэ?

“Манай хоршоо” багц нь ХАА-н хоршоог удирдах тухай сургалтын багц юм.

“Манай хоршоо” сургалтын багц нь ХАА-н хоршооны менежментийг бэхжүүлэх зорилготой ба ингэснээр хоршоод гишүүддээ илүү чанартай, үр дүнтэй үйлчилгээ үзүүлнэ.

1 Үйлчилгээний салбар бол ажлын байр бий болгодог дэлхийн хамгийн чухал салбар юм. <http://www.ilo.org/public/english/dialogue/sector/sectors/agri/emp.htm> (2011.10.07).

2 Агритеппагийн тухай <http://www.agriterra.org/en/text/about-agriterra> (2011.09.22).

3 Эх сурвалж: Дэлхийн 300 хоршоо, <http://www.global300.coop> (2011.10.07).

Энэхүү сургалтын багцыг 1978-1990 оны эхэн үед ОУХБ-аас боловсруулсан “Хоршооны менежментийн сургалтын хөтөлбөр”-т үндэслэн боловсруулав. Одоогийн байдлаар “Манай хоршоо” сургалтыг ОУХБ-ын Африк тивийн хоршооллын хэлтэс болон Хоршооллын салбаруудын хамтын ажиллагааны санаачлагаар зохион байгуулдаг. Энэ бол хоршооллын хөгжлийн агентлаг, хоршооллын коллеж, хоршооллын байгууллага, ХАА-н үйлдвэрлэл эрхлэгч, их сургууль, НҮБ-ын агентлагууд зэрэг маш олон байгууллагын өргөн хүрээтэй хамтын ажиллагааны үр дүн юм. Эдгээр хамтрагч байгууллагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тус гарын авлагын эхний хэсгийн жагсаалтаас үзэж болно. Энэхүү гарын авлагын

зорилго нь ХАА-н хоршооны менежерүүдийг (одоо ажиллаж байгаа болон цаашид ажиллах сонирхолтой) зах зээлийн баримжаатай хөдөө аж ахуйг хөгжүүлэх явцад хоршоонд байнга тулгардаг үндсэн сорилтуудыг тодорхойлж, шийдвэрлэх чадвартай болгоход оршино.

Дээр дурьдсанчлан хоршоо гишүүдийнхээ эрх ашиг, бизнесийн боломж ба нийгмийн төлөө үзүүлэх үйлчилгээнийхээ дунд өөрөө өөртэйгөө зөрчилдөх тохиолдол байдаг. Иймд хоршооны менежер нь гишүүдээ ХАА-н үйлдвэрлэлийн орцоор хангах, бүтээгдэхүүнийг нь борлуулах зэрэг ХАА-н хоршооны нийтлэг үйлчилгээний талаар оновчтой шийдвэр гаргадаг байх хэрэгтэй.

Эдгээр асуудлыг “Манай хоршоо” сургалтын багцад тусгасан.

- 1 Хөдөө аж ахуйн хоршооны тухай үндсэн ойлголт
- 2 Хоршооны үзүүлэх үйлчилгээ
- 3 ХАА-н үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт
- 4 Хоршооны маркетинг

“Манай хоршоо” багц хэнд зориулагдсан бэ?

“Манай хоршоо” багц нь ХАА-н хоршооны менежер, менежерийн үүрэгт ажилтай ямар нэг байдлаар холбоотой гишүүнд зориулагдсан. Мөн ХАА-н хоршооны идэвхтэй гишүүд, тодорхой туршлага хуримтлуулсан хүмүүст зориулагдсан. Харин ХАА-н хоршоог анхлан байгуулж байгаа хүмүүст энэ материал тохиромжгүй. “Манай хоршоо” багц нь ХАА-н хоршоодыг чадавхжуулах сургалт зохион

байгуулдаг дараах байгууллага, хувь хүмүүст чухал хэрэгцээтэй. Үүнд:

- Дундын хоршоо, аймгийн холбоо, үндэсний холбоо зэрэг хоршооны байгууллагын удирдлага, менежер
- Хоршооны коллеж, ТББ, хувийн хэвшлийн ба бүх төрлийн сургалтын байгууллагад ажилладаг хоршооны сургагч багш
- Төрийн байгууллагын хоршооны нэвтрүүлэх үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн.

Багцад юу орсон бэ?

Тус сургалтын багцад доорх зурагт үзүүлсний дагуу сургагч багшийн гарын авлага, сургалтын 4 модуль багтсан.

“Манай хоршоо” багцын сургагч багшийн гарын авлагад суралцагчдын оролцоог хангасан, суралцагч төвтэй сургалт зохион байгуулахад ашиглах сургалтын загвар хөтөлбөр, цуврал хичээл багтсан.



Модуль тус бүр хэд хэдэн сургалтын сэдвээс бүрдсэн. Сургалтын сэдэв бүрт товч агуулга, бодит амьдралын туршлага, дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаа явуулж буй ХАА-н хоршооны менежментэд тулгардаг нийтлэг бэрхшээлийг шийдвэрлэх арга замууд багтсан.

суралцахад туслах зориулалттай сэдвийн агуулга, тодорхойлолтын тайлбар, бие дааж гүйцэтгэх даалгавартай. Модуль ба сэдвийг нэг нэгнээс нь үл хамааран тусад нь суралцах боломжтой бөгөөд сургалтын хэрэгцээндээ тохируулан ямар ч дарааллаар хэрэглэж болно.

Мөн бие даан суралцагч сэдвийн агуулгыг өөрийн хоршоо, нөхцөл байдалд тохируулан

Доорх хүснэгтээр сургалтын багц гарын авлагын агуулгын бүтцийг харууллаа.

1	Хөдөө аж ахуйн хоршооны тухай үндсэн ойлголт
Сэдэв 1	Хөдөө аж ахуйн хоршооны тухай үндсэн ойлголт
Сэдэв 2	Хоршоонд тулгарч буй сорилтууд
Сэдэв 3	Хоршооны засаглал
Сэдэв 4	Менежмент, хөрөнгө бүрдүүлэлт ба санхүү

2

Хоршооны үзүүлэх үйлчилгээ

Сэдэв 1

Гишүүдийн хэрэгцээ гэж юу вэ?

Сэдэв 2

Ямар үйлчилгээ үзүүлэх вэ?

Сэдэв 3

Хэн үйлчилгээг үзүүлэх вэ?

3

ХАА-н үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт

Сэдэв 1

ХАА-н үйлдвэрлэлийн орцын худалдан авалт

Сэдэв 2

Хадгалалт ба нөөцийн удирдлага

Сэдэв 3

Бараа үйлчилгээний борлуулалт

4

Хоршооны маркетинг

Сэдэв 1

Маркетингийн үйлчилгээ

Сэдэв 2

Маркетингийн стратеги

Сэдэв 3

Баталгаажуулалт

“Манай хоршоо” онлайнаар

“Манай хоршоо” нь зөвхөн сургалтын багц материал төдийгүй сургагч багш нарт зориулсан зайны сургалтын хөтөлбөр, явуулын сургалтын хэрэгсэл зэрэг холбогдох үйлчилгээ, арга хэрэгслийг агуулсан вэб хуудастай.

(www.agriculture-my.coop).

Багцын сургагч багшийн гарын авлагад суралцагчдын оролцоог хангасан, суралцагч төвтэй сургалт зохион байгуулахад ашиглах загвар сургалтын хөтөлбөр, цуврал хичээл, бодит жишээ багтсан.



Сургагч багшийн гарын авлагын тухай

Сургагч багшийн гарын авлагын зорилго

- Сургагч багш нарыг сургалтын бодит жишээ, хөтөлбөр ашиглан харилцан идэвхтэй, туршлагад суурилсан ХАА-н хоршоодын менежментийн сургалтуудыг зохион байгуулах чадвартай болгох;
- Тухайн сэдвээр мэдлэг солилцох зорилгоор төрөл бүрийн сургалтын арга хэрэгслүүдэд сургагч багш нарыг сургах;
- Мэдлэг хуваалцах болон сургалтын үйл явцыг сонирхолтой болгох таатай орчинг бүрдүүлэх.

“Манай хоршоо” сургалтыг удирдан явуулах сургагч багшийн стандарт:

- Манай хоршоо бүх модулийн талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй байх;
- Сургалтыг удирдах чадвар сайтай, насанд хүрэгчдийн сургалтын талаар ойлголттой байх;
- Оролцогчдын ялгаатай талуудыг сургалтын гол үнэ цэнэ хэмээн хүндэлдэг байх;
- Оролцогчдын дунд итгэл үнэмшил бий болгож чаддаг байх;
- Оролцогчдын санал бодлыг нээлттэйгээр сонсох нь сургалтын үнэ цэнэтэй нэг арга гэж үздэг байх.

Гарын авлагад юу багтаж байгаа вэ?

Цуврал хичээлүүд нь сургалтын модулиуд болон тэдгээртэй холбоотой сэдвүүдээс мэдлэг, ур чадвар болон зөв хандлагыг эзэмших, туршлага олж авахад нь суралцагсдад туслах боломжтой байхаар боловсруулагдсан. Сургагч багш тухайн зорилтот оролцогчдын бүлэгт хамгийн тохирох сургалтын аргыг сонгож болох бөгөөд хичээлүүд нь тухайн нөхцөл байдалд тохируулан хялбархан ашиглаж болохоор зохиогдсон болно.

Мөн жишээ болгож зарим сургалтын хөтөлбөрүүдийг оруулсан байгаа. Энэ нь нэг долоо хоногийн сургалтын стандартын дагуу сургалтын сэдэв, модулийг хэрхэн зохион байгуулж болох талаар танд санаа өгөх болно.

Та бүхнийг ХАА-н хоршоон дээр очиж туршлага судлах аялал зохион байгуулахыг онцгойлон санал болгож байна. Бусад хоршоодын бодит үйл ажиллагаатай танилцах, хоршооны удирдлагууд, ажилтнууд, гишүүдтэй мэргэжил аргагүйн туршлага солилцох нь сургалтын агуулгыг орчин нөхцөлд нь суралцахад тусалдаг. Туршлага судлах аялалын дараа сургалтаар олж авсан мэдлэг болон бодит туршлага хоорондын уялдааг холбох зорилгоор дүгнэлт хичээл орох шаардлагатай.

Сургалтын тусгай аргачлал

Манай хоршоо сургалтын багц нь дор дурьдсан байдлаар дүгнэж болох тусгай аргачлалуудыг нэгтгэсэн. Үүнд:

Оролцооны - суралцагч төвтэй - нөхцөл байдалд суурилсан - уян хатан төлөвлөлттэй - туршлагад суурилсан - хоршооны үнэт зүйлс, зарчим - олон төрөлт ялгаатай байдлын нэмэлт үнэ цэнэ.

Суралцагч төвтэй оролцоог хангасан

Энэхүү сургалтын багцыг боловсруулах явцад ХАА-н хоршоодын хувь хүний болон байгууллагын сургалтын хэрэгцээнд үе шаттайгаар үнэлгээ хийсэн болно. Үүнд үндэслэн суралцагч төвтэй сургалтын материалуудыг боловсруулсан.

Уян хатан, тухайн нөхцөлд ашиглаж болохуйц

Модуль бүрт хэд хэдэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөж оруулсан бөгөөд сургагч багш эдгээрээс сонгон өөрчилж сургалтандаа ашиглаж болно. Эдгээр нь орон нутгийн нөхцөл байдалд тохируулан өөрчлөхөд хялбар ба сэдвийн дагуу өгөгдсөн жишээ, бодит түүхийг тухайн орны бодит жишээгээр сольж болно.

Туршлага судлах

Сургалтын үйл ажиллагаанд ХАА-н хоршоодын талаарх онолын мэдлэг оруулахаас гадна төдийгүй багш болон суралцагчдыг ХАА-н хоршоодыг удирдахад шаардагдах мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшихэд өөрсдийн өмнөх туршлага, ойлголтыг ашиглахыг дэмжиж идэвхжүүлдэг онцлогтой.

Дэлхий нийтийн үнэт зүйлс болон олон талт байдалтай уялдуудах

Энэ багц нь дэлхийн олон орны ХАА-н хоршоодын чадавхийг хөгжүүлэх зорилготой. Сэдэв болон агуулгууд нь Олон улсын хоршооллын холбоо (ОУХХ) ба Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ОУХБ)-аас гаргасан Хоршооны үнэт зүйл, зарчим, Хоршоог дэмжих тухай 193 дугаар зөвлөмж (2002),⁴ Тогтвортой хөгжил ба үйл ажиллагааны 10 жилийн хугацааны мэдлэг туршлагад суурилсан. Сургалтын явцад оролцогчид эдгээр зарчмуудыг орон нутгийн хэтийн төлөв болон туршлагаасаа маш тодорхой ойлгож авна. Гол ойлголтуудын ялгаа, сургалтын багц гарын авлагын зарчим нь олон улс үндэстэн, хүйс, орчны ялгаатай туршлагаудад суурилсан.

Сургалтын үйл ажиллагааны бүтэц

Сургалтын энэ багцад оруулсан хичээлүүд нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагааны нэр;
- Модулын агуулга, сургалтын сэдэв;
- Сургалтын зорилго;
- Арга зүй;

4 ОУХБ-ын Хоршоог дэмжих тухай 193-р зөвлөмж (2002), <http://www.ilo.org/ilolex/cgi-lex/convde.pl?R193> (2011.10.22).

- Зөвлөгөө;
- Сургалтын материалууд;
- Хугацаа г.м.

Сургалтын загварыг цахим хуудаснаас татаж авах боломжтой. Өөрийн орны онцлогт тохируулан нэмэлт өөрчлөлт хийж болно.

Сурах үйл ажиллагааны агуулга

Агуулга	“Манай хоршоо”
Модуль 1	Хоршооллын шоо. Хоршооны тухай үндсэн ойлголт, зарчмууд. Хоршооны гишүүнд тавигдах шаардлага. Хоршооны мэдлэгийн өртөө. Хоршоогоо товч танилцуулъя. Туршлага солилцох дасгал ажил. Хоршооны орчин. Хамтын ажиллагааны шинжилгээ. Өртгийн сүлжээний дасгал ажил. Засаглалын сорилтууд. Оюуны бичиглэлийн дасгал ажил.
Модуль 2	Хэрэгцээг тодорхойлох. Олон төрлийн арга хэрэгслийг хослуулан хэрэглэх дасгал ажил. Баталгаажуулалтын тогтолцоон дахь давхар тойргийн дасгал ажил. Оюуны зураглал ба хэрэгцээг эрэмбэлж үйлчилгээтэй холбох. Нөхцөл байдлын шинжилгээ. Хоршоо гишүүддээ үйлчилгээ үзүүлэхийн тулд чадавхи хэрхэн сайжруулах вэ?
Модуль 3	Бие биедээ туслах аргаар тодорхой сорилтуудыг шийдвэрлэх нь. Хадгалалт болон агуулахын удирдлагын өртөөчилсөн аялал дасгал ажил. Үнийн бодлого боловсруулах. Мэргэжлийн шинжээч нарын мэтгэлцээний дасгал ажил.
Модуль 4	Өртгийн сүлжээний бодит жишээ: Үйл ажиллагаагаа сайжруулах. Шилдэг 100 жагсаалт. Зах зээлийн мэдээлэл: Хоршооны шинжилгээ Маркетингийн хольцын хөлөгт тоглоом. Баталгаажуулалтын тогтолцооны Давхар тойргийн дасгал ажил
4 Модулийн нэгтгэл	“Манай хоршоо” чөлөөт орон зай “Манай хоршоо” туршлага судлах аялал “Манай хоршоо” үнэлгээний дасгал ажил.

Сургалтын 4 модульд оролцооны арга зүйг ашиглахыг онцгой анхаарсан байна. Насанд хүрэгчдийн сургалт ялангуяа энэхүү сургалтын гарын авлагад хэрэглэгдэж буй арга зүйн талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл Му.соор Community (www.agriculture-my.coop) цахим хуудас ашиглах боломжтой. Энэ цахим хуудаснаас сургагч багш нар мэдлэгийн өртөө, хамтын ажиллагааны схем, оюуны бичиглэл, чөлөөт орон зай, давхар тойргийн арга, өртөөчилсөн аялал, шилдэг 100 жагсаалт, бодит жишээ судлах, бие биедээ туслах арга, бодит түүх ярих, оюуны зураглал гэх мэт оролцооны аргуудын талаарх ерөнхий мэдээллийг олж авах болно.

Сургалтын бэлтгэл:

Оролцогчдын анхааралд,

Та бүхэн "Манай хоршоо" сургалтад ирэхдээ дараах мэдээллийг бэлдэж авчирна уу:

- ➔ Хоршооны гишүүдийнхээ болон бүтээгдэхүүний жагсаалт (боломжтой бол бүтээгдэхүүний дээжийг авчрах);
- ➔ Хоршооны үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, тухайлбал ХАА-н үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт, үйлдвэрлэл, боловсруулалт, борлуулалт, зах зээл (үнэ, үйлчлүүлэгч, хэмжээ) зэрэг;
- ➔ Бүтээгдэхүүнээ борлуулж буй зах зээлийн борлуулалтын сувгуудын тодорхойлолт;
- ➔ Бүтээгдэхүүн борлуулалтын үе шат бүрийн үнэ (бөөний, жижиглэнгийн, хэрэглэгчийн, үйлчлүүлэгчийн, дотоод болон гадаад зах зээлийн);
- ➔ Хоршооны зохион байгуулалтын бүтэц;
- ➔ Хоршооны гишүүдийн талаарх мэдээлэл (тоо, хүйс, нас, эрхэлдэг аж ахуйн хэмжээ, санхүүгийн нөхцөл байдал, чадвар, байгалийн нөөц г.м);
- ➔ Хоршооныхоо бүтээгдэхүүнийг танилцуулсан сурталчилгааны материалууд (бүтээгдэхүүний танилцуулга, сурталчилгааны сонин г.м);
- ➔ Хоршооны үйлдвэрлэдэг бүтээгдэхүүн савалгаатай бол (хайрцаг, сав, лааз, шил уут г.м) жишээ болгож сав баглаа, боодлын загвар, хаяг шошгийг авчрах.

Баярлалаа

Зохион байгуулагчид

Сургалтанд ашиглах материалыг шалгах хуудас:

- ❑ Сургалтын гарын авлага, "Манай хоршоо" сургалтын 4 модуль, явуулын сургалтын хэрэгслүүд (өөрийн сонголтоор)
- ❑ Компьютер, хэвлэгч, шаардлагатай бол чанга яригч
- ❑ Проектор, дэлгэц (цагаан хана)
- ❑ Цааснууд (том, жижиг, өнгийн, цагаан цаас) самбарын үзэг/үзэгнүүд (өнгийн, хар), тэмдэглэлийн дэвтэр, самбарын цаас, ватум
- ❑ Бичгийн хэрэгсэл (хайч, утас, цавуу, скоч, цоолтуур)
- ❑ Идэвхжүүлэгчийн цаг баримтлахад ашиглах зүйлс (цаг, бугуйн цаг, хонх)
- ❑ Энгэрт зүүх нэрийн хуудас
- ❑ Дасгал болон тарааж өгөх материал тус бүрийг олшруулсан хуулбарууд
- ❑ Хувилагч машин
- ❑ Маркетингийн хольцын хөлөгт тоглоом
- ❑ Хоршооллын шоо

**Сургалтын үйл
ажиллагаа**

1.0: “Манай хоршоо” нийгмийн бүлгийн асуулга

Оролцогчидтой танилцах, орон нутгийн хоршоодын нөхцөл байдлыг мэдэх зорилгоор “Манай хоршоо” сургалтыг эхлэхийн өмнө танилцах үйл ажиллагааг зохион байгуулах нь зүйтэй. Үүний тулд “Манай хоршоо” нийгмийн судалгааны асуулгыг та бүхэнд санал болгож байна. Энэ юу гэсэн үг вэ?

Хоршооны нөхцөл байдал болон оролцогчдод холбогдолтой асуултууд бэлтгэнэ. Тухайлбал

- Хаанаас ирсэн?
- Аль хоршоонд ажилладаг/аль хоршооны гишүүн бэ?

Хариулт бүрийг илэрхийлэх газрын байрлалыг (самбарын цаас, тэмдэг, карт зэргийг ашиглан) тодорхойлно. Жишээлбэл: Ази, Америк, Африк, Европ, Арабын нэгдсэн улсууд, аймаг гэсэн булангуудыг гаргаж болно. Оролцогчдыг өөрсдийн ирсэн бүс рүү очихыг урина. Үүнтэй адилаар сэдэвт булангуудыг (хоршоодын олон төрлүүдээр) гаргаж болно. Оролцогчдыг өөрт нь хамааралтай булан эсвэл бүлэг рүү очих зааврыг байнга өгнө.

Бүлгүүдэд ярилцах, нийгэмших тодорхой хугацаа өгч, өөр өөр бүлгүүдийн зарим оролцогчидтой санамсаргүй байдлаар ярилцсанаар оролцогч бүрийн хаанаас ирсэн нь тодорхой болно.

Эцэст нь оролцогчдыг хоршооны хэдэн жилийн туршлагатай гэдгээр нь жагсахыг хүснэ. Энэ нь оролцогчдод хоорондоо ярилцах боломж олгох ба үүний үр дүнд нэг жилийн туршлагатай оролцогчоос эхлэн 25 жилийн туршлагатай хүртэл жагссан нэг эгнээ бий болно. Бүх оролцогчдын хоршооны туршлагын жилийн нийлбэрийг гаргах ба (магадгүй нийлээд 400 жилийн туршлага ч гарч болно) энэ нь “Манай хоршоо” сургалтын туршид тэдний цуглуулсан туршлага, оюун ухаандаа итгэх нь хамгийн чухал сургалтын аргууд гэдгийг тодотгоно.

Модуль 1:

ХАА-н хоршооны тухай үндсэн ойлголт

1.1: Хоршооллын шоо.

Хоршооны тухай үндсэн ойлголт ба зарчмуудын танилцуулга



Зорилго

- ХАА-н хоршооны тухай үндсэн ойлголт;
- Хоршооллын зарчмуудыг тодорхой нөхцөлд хэрэглэх.



Арга зүй

Хичээлийн нээлт (15 минут)

Сургагч багш оролцогчдод дараах хоёр асуулт тавина:

- Хоршоо гэж юу вэ?
- Хоршооны бусад аж ахуйн нэгжээс ялгагдах онцлог юу вэ?

Оролцогчид энэ 2 асуултын дагуу бичил бүлгээр ярилцана. Бичил бүлэг гэдэг нь 2-3 оролцогчидтой энгийн жижиг бүлэг бөгөөд энэ сэдвийг маш богино хугацаанд хэлэлцэхээр санаандгүй бүрдсэн бүлэг юм. Сургагч багш 5 минутын дараа бүлгийн хэн нэгнээр бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнг самбарын цаасан дээр бичүүлж түүнийг нь хичээлийн явцад танилцуулах юм. Бусад бүлгүүд санал зөвлөмж гаргаж, өөрсдийн үр дүнгийн дагуу хувь нэмрээ оруулна.

Сургагч багш ОУХБ болон ОУХХ-оос гаргасан хоршооны тодорхойлолтыг танилцуулна.

“Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ”.

Хичээлийн асуулт хариултын хэсэгт оролцогчид тодорхойлолтыг бүрдүүлж байгаа элементүүдэд шуурхай дүн шинжилгээ хийж, үр дүнгээ бичил бүлгүүдэд болон нэгдсэн хэлэлцүүлгийн үед тайлагнана.

- Бие даасан
- Хувь хүн
- Сайн дураараа
- Нийтлэг хэрэгцээ
- Дундын эд хөрөнгө
- Ардчилсан хяналт бүхий аж ахуйн нэгж

Хоршооллын шоог танилцуулах (30 минут)

1-р тойрог (15 минут)

Оролцогчдыг таван бүлэг болгон хувааж бүлэг бүрт 1-2 ш хоршооллын шоо (нийт 7 шоо) тарааж өгнө. Хоршооллын шоо гэдэг нь цаасаар хийсэн дөрвөлжин шоо бөгөөд нэг талд нь хоршооллын зарчмуудын нэгийг бичиж бусад талууд нь хоосон байна. Оролцогч бүрт хоршооллын зарчмын талаарх өөрийн ойлголтоо бичих цавуутай өнгийн цаас өгсөн байна. Энэхүү цаасан дээр оролцогчид хоршооллын зарчмын талаарх өөр өөрсдийн ойлголтоо бичээд шооны хоосон талуудад наана. Ингээд хоршооллын бүх шооны хоосон талуудад таван өөр төрлийн тайлбар наана.

Бүлэг доорх чиглүүлэх асуултуудын дагуу ялгаатай тайлбаруудыг хэлэлцэнэ.

Энэхүү тайлбараар та ямар утгыг илэрхийлж байна вэ?

Таны бодлоор энэ зарчим ямар утгатай вэ?

Энэ зарчмыг баримтлахад танд ямар бэрхшээлүүд тулгарч байна вэ? Өөрийн хоршооны бодит жишээнээс дурьдана уу.

Доорх хоршооллын шоонуудыг бүлгүүдэд хуваарилан өгнө.

Шоо 1. Сайн дурын нээлттэй гишүүнчлэл

Шоо 2. Гишүүдийн ардчилсан хяналт

Шоо 3. Гишүүдийн эдийн засгийн оролцоо

Шоо 4. Бие даасан байдал

Шоо 5. Боловсрол, сургалт, мэдээлэл

Шоо 6. Хоршоод хоорондын хамтын ажиллагаа

Шоо 7. Нийтийн сайн сайхны төлөө

2-р тойрог (15 минут)

Бүлгүүд өөрсдийн ажилласан хоршооллын (зарчмууд болон тайлбар наасан) шоогоо бусад бүлэгтээ өгч үнэлүүлнэ. Бүлэг тайлбаруудыг хэлэлцэж аль тайлбар нь утгаараа хамгийн тохиромжтой байгааг сонгож эцсийн тодорхойлолтыг гаргана. Гаргасан тодорхойлолтоо том цаасан дээр бичиж сургагч багшид өгнө.

3-р тойрог (15 минут)

Сургагч багш Сэдэв 1-д үндэслэн ялгаатай зарчмууд болон тодорхойлолтуудын талаар ерөнхий ойлголт өгч санал бодлоо хэлнэ.






Ашиглах материал

- 7ш хатуу цаасан шоо
- Өнгө өнгийн цавуутай цаас
- Оролцогч бүрт үзэг
- Самбарын цааснууд
- Самбарын үзэг
- Цаасан скоч

Зөвлөгөө

Хоршооллын шоог хийх зааврыг доор үзүүлэв.

Хэмжээс бүхий талуудыг улаан өнгөөр тэмдэглэнэ.



Хугацаа

1 цаг

1.2: Хоршооны гишүүнд тавигдах шаардлага

Хоршооны мэдлэгийн өртөө. Дугуй ширээний албан бус сургалт



Зорилго

- ХАА-н хоршооны гишүүн байх шалтгааныг дахин ярилцах;
- Хоршооны гишүүнчлэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаануудыг нээн илрүүлэх;
- Өөр өөр аж ахуй эрхлэгч хүмүүсээр гишүүнчлэлээ нэмэгдүүлэх.



Аргазүй

Оролцогчдыг дөрвөн өөр ширээнд хуваарилж (нэг ширээнд 6-7 хүн байхаар) өөрсдөөр нь сонгуулсан ширээний ахлагчаар удирдуулна. Ширээ бүр тодорхой нэг хоршооны асуулт дээр төвлөрөн ажиллана.



Асуултууд:

- Хоршоо байгуулах болон хоршоонд гишүүнээр элсэх шалтгаан юу вэ?
- Гишүүдийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэхэд хоршоо ямар боломжит арга хэмжээ авдаг вэ?
- Өөр өөр аж ахуй эрхлэгч хүмүүсээр гишүүнчлэлээ нэмэгдүүлэх нь яагаад чухал вэ?
- Гишүүд хоршооноос гарах шалтгаан юу вэ?

Ширээг самбарын том цаас юм уу бор цаасаар бүтээнэ. Бүлгүүд өөрт оногдсон асуултуудын дагуу ярилцана. Ширээний ахлагч нь оролцогчдыг тэмдэглэл, зураглал, диаграмм зэргийг ширээн дээрх цаасан дээр шууд хийхийг дэмжинэ. Гарсан гол санаануудыг тэмдэглэж байхыг ширээний ахлагчид зааварлана.

Асуулттай холбоотой гол санаануудыг онцгой анхааран өөрсдийн бодол саналаа илэрхийлэхийг оролцогчдод зааварлана. Багийн ахлагч нар оролцогчдын яриаг идэвхтэй сонсож сонирхолтой холбоос, загвар, нэмэлт асуулт зэргийг тавьж болно.

Энэ ярилцлага ойролцоогоор 15-30 минут үргэлжилнэ. Ширээний ахлагчаас бусад нь дараагийн ширээ лүү шилжинэ.


Ширээний ахлагч ирсэн бүлэгт өөрсдийн тайлбарыг тоймлон танилцуулж, санаа давтахгүйгээр өөрсдийн саналаа нэмэрлэхийг хүснэ.

Оролцогчид заавал бүх ширээн дээр очих шаардлагагүй (өгөгдсөн цагаас шалтгаалан 2-3 ширээн дээр очиж болно) бөгөөд хэдэн тойргийн дараа дүгнэлт хийж хичээлээ төгсгөнө.

Өрөөний хэмжээ, зохион байгуулалт зэргээс шалтгаалан ширээ бүрийн ахлагч нар нэгтгэл болон гол санаагаа өөрийн ширээнийхээс бусад нийт оролцогчдод эсвэл нэгдсэн хэлэлцүүлгийн үед танилцуулна.

Ширээний ахлагч дүгнэлтээ танилцуулсны дараа бусад оролцогчдоос сонирхолтой санал дэвшүүлэх, цаашид юу суралцах хүсэлтэй байгааг сонсоход зориулж оролцогчдод цаг гаргаж өгч болно.

Оролцогчид ширээ хооронд мэдлэгээ солилцсоноор нэг ойлголтонд хүрэх боломжийг бүрдүүлж өгснөөрөө энэ аргын ид шид оршино.



Ашиглах материал

- 4 ширээ, сандал
- Ширээ бүтээх бор цаас
- Ширээ бүрт өнгө өнгийн самбарын үзэг



Зөвлөгөө

Дүгнэлтийн үеэр сургагч багш “Манай хоршоо” сургалтын багцын эхний модулиас (Сэдэв 3) гишүүний үүргийн гол санаануудаас дурдаж болно.

Сургагч багш:

- Малчид тариаланчид хоршоонд элсэх шалтгааныг харуулсан Хүснэгт 1.1-ийг үзүүлэх.
- Хоршооны гишүүний үүргүүдээс хамгийн чухал 3 элементийг сануулах.
- Гишүүний үүргийн талаар сонирхолтой бодит жишээг үзүүлэх (Сэдэв 3-ийн бодит жишээ 3.2-ын мал нядалгааны хоршооны болон бодит жишээ 3.3 дахь Архангай аймгийн “Баялаг хангайн сор” дундын хоршооны туршлага г.м).



Хугацаа

Доод тал нь 60 минут цаашлаад 2 цагаас ихгүй байхаар “Дэлхийн мэдлэгийн өртөө” хичээлийг төлөвлөж, асуултууд нь давтагдахгүй, оролцогчдыг уйдаахгүй байхад анхаарна.

1.3. Танай хоршооны тухай. Бодит түүх ярих дасгал ажил



Зорилго

- Оролцогчдын хоршооны алсын хараа, эрхэм зорилгыг хэлэлцэх;
- Оролцогчдын хоршооны хосломол чанаруудыг тодорхойлох;
- Оролцогчдын хоршооны үнэт зүйл, зарчмыг судлах.

“Бодит түүх ярих” гэдэг нь сонирхолтой болон холбоотой аргаар мэдээллийг дамжуулдаг харилцааны хэрэгсэл юм. Ингэхдээ тухайн түүхийг сонсож буй хүмүүсийн анхаарлыг татаж, түүнээс ямар нэгэн туршлагыг олж авах боломжийг бүрдүүлж сэтгэгдэл үлдээх үг хэллэгийг хэрэглэж хүүрнэсэн байдлаар ярих шаардлагатай.



Арга зүй

Оролцогчдоос өөрийн хоршооныхоо тухай ярихыг хүснэ. Сургагч багш хоршооны түүхээ хэрхэн ярих талаар тодорхой жишээгээр тайлбарлана. Сургагч багш “Манай хоршоо” багцын модулиудад орсон бодит түүх эсвэл хувь хүний түүх (Сэдэв 2-ын бодит жишээ 2.1-д Ховд аймгийн “Алтайн уулсын оргил” дундын хоршоо)-ээс ашиглаж болно.

Оролцогчид сэдэвтэй холбоотой, сэтгэгдэл төрүүлэхүйц түүх зохиохыг хүсвэл дараах санаануудыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Түүхийг илүү үр дүнтэй болгохын тулд сонирхолтой талуудыг нь тодотгон хүмүүсийн сонирхлыг татаж, сэтгэгдэл төрүүлэх элементүүдийг тусгах;
- Бусад оролцогчдод илүү ойлгомжтой байлгах зорилгоор түүхийг жүжигчилсэн байдлаар үзүүлэх;
- Хүмүүс үгээс илүү үйл явдлын дарааллыг илүү тогтоодог учраас үйл явдлыг дүрслэх;
- Түүх ярих явцыг улам төгс болгохын тулд зураг, дуу чимээ, дүрс бичлэг ашиглах;
- Задлан шинжилгээнээс татгалзаж, оролцогчдод зориулж хүүрнэсэн байдлаар ярихад илүү анхаарах;
- Цаашдаа оролцогчдын бүтээлч байдлыг хязгаарлах, бууруулахад нөлөөлж болзошгүй хэтэрхий тулгасан, эсвэл ёс зүйгүй хэлэлцүүлгээс татгалзах.

Оролцогчдод хоршооны түүхээ бичих 30 минутын хугацаа өгнө. Тэд түүхээ танилцуулахдаа үзүүлэн таниулах материал(зураг, бичлэг, дүрслэл зэрэг)-уудыг ашиглаж болно. Оролцогчдод түүхээ ялгаатай хэсгүүд бүхий бүтцийн дагуу бичихэд туслах тараах материалыг тарааж өгнө. Дараа нь үүнийгээ оролцогчид өөр хоорондоо хоршооны түүхээ ярих үед ашиглаж болно.

Сургагч багш түүх бичих үйл ажиллагааг эхлүүлэх сэдэл өгөх, чиглүүлэх асуултуудыг хуваалцаж болно.

- Та бүхэн яагаад хоршоо байгуулсан бэ?
- Танай хоршооны алсын хараа, хүсэл зорилго юу вэ?
- Танай хоршооны бизнесийн гол үйл ажиллагаа юу вэ?
- Танай хоршооны онцлог юу вэ?
- Танай хоршооны нийгмийн чиг хандлага юу вэ?

- Танай хоршоо хэрхэн хувьсаж өөрчлөгдсөн бэ? Танай хоршоо өөрчлөлтөнд хэрхэн дасан зохицсон бэ?

Бэлтгэл үе дууссаны дараа оролцогчид жижиг бүлэгт (6-8 хүн) хуваагдаж өөрсдийн хоршооны түүхийг өгүүлж, асуулт тавин харилцан ярилцаж болно. Энэ туршлагаа хуваалцах үйл явц нь 45 минутаас хэтрэхгүй байна. Оролцогч бүр 5 минутанд багтаан өөрийн түүхээ ярина. Бүх түүхээ хуваалцсаны дараа сургагч багш доорх асуултуудын хариуг олох бүх оролцогчдыг хамарсан дүгнэлтийг зохион байгуулна. (30 минут)

- Эдгээр ялгаатай түүхүүдээс гишүүдийн сонирхол, бизнесийн болон нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа хоорондын ямар нэгэн зөрчилдөөнийг та олж илрүүлсэн үү?
- Эдгээр түүхүүдэд хөдөө аж ахуйн хоршоодын ямар ялгаатай үйл ажиллагаануудын талаар өгүүлж байна вэ?
- Ямар төрлийн үйлчилгээг хоршоо үзүүлж байна вэ?(Хүснэгт 2.1-г харна уу)
- Эдгээр түүхүүдээс олж авсан хамгийн чухал 3 зүйл юу вэ?



Ашиглах материал

- Янз бүрийн сэтгүүлүүд, хайч, цавуу;
- Оролцогчид өөрсдийн түүхээ тэмдэглэх самбарын цаас;
- Оролцогчдын тоогоор олшруулсан тараах материал.

Зөвлөгөө

- Цээжлэхэд хялбар гарчигийг оролцогчдоор бодож олуулах;
- Оролцогчид өөрийн хоршооны түүхээ танилцуулахад ашиглах үзүүлэн таниулах материал хийхэд зориулж хуучин сэтгүүлүүд тарааж өгөх;
- Оюуны зураглал⁵ болон зургаар баяжуулах⁶ зэрэг боломжит аргуудыг сонгон ашиглаж түүхийг нүдэнд харагдахуйц болгох;
- Хамгийн их сэтгэл догдлуулсан түүхээ “Манай хоршоо” цахим сургалтын материалуудад илгээхийг оролцогчдод уриалж болно. Ирүүлсэн түүхүүдийг бусад сургалтын үйл ажиллагаанд ашиглаж болох ба эдгээр нь хоршоодод туршлага болно.
- Сургалтын үйл ажиллагааны үлдсэн хугацаанд эдгээр түүхүүдийг харагдаж байхаар сургалтын өрөөнд байрлуулна.



Хугацаа

1 цаг 30 минут – 2 цаг

5 Оюунаа зурагла, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Олон улсын техникийн хамтын ажиллагааны L&T блог, <http://itcilo.wordpress.com/2009/03/02/map-your-mind/> (2011.10.22).

6 Баялаг зураг, Википедиа, http://en.wikipedia.org/wiki/Rich_picture (2011.10.22)

“Танай хоршоо” тараах материал

Гарчиг	
Түүх өгүүлэгчийн нэр	
Сонсогчдын нэрс	
Хоршооны газар зүйн байршил. Үйл явдлын цаг хугацаа, байрлал	
Үйл явдал болсон байршлыг нарийн тодорхойлох	
Шинж чанар: түүхэнд гарч буй дүр, ямар зан чанартай, хандлагатайг тодорхойлж, хэний тухай өгүүлж байна вэ?	
Сорилт: үйл ажиллагааг өрнүүлэхэд нөлөөлсөн асуудал, хэрэгцээ болон даалгавар	
Үйл ажиллагаа: өөрчлөх явцын өмнөх, үргэлжлэх болон дараах үйл явдлын дараалал	
Шийдвэр: туршлагаас суралцах болон мэдээлэл түгээх	
Төсөөлөл болон дүрслэл: түүхийг сэргээн санаж эргүүлэн ярихад туслах	

1.4 Хоршооны орчин. Хамтын ажиллагааны шинжилгээ



Зорилго

Хоршооны менежерийн хувьд тэдний үйл ажиллагаа явуулж буй эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын орчны талаарх ойлголтыг оролцогчдод өгөх;

Суралцагчид хоршооны орчинд оролцогчид хоорондоо хэрхэн холбогддог, хэрхэн нөлөөлдөг, тэдний зорилго юу болох зэрэг харилцаа хамаарлыг зураглах.



Арга зүй


Сургагч багш оролцогчдыг ажлын 6-8 хүнтэй хэсэгт хуваана (хэрвээ оролцогчид нь өөр өөр хоршооноос ирсэн тохиолдолд бүлэг нэг сонгогдсон бодит жишээ эсвэл хоршооны туршлага дээр ажиллана).

Бүлэгт дараах зааварчилгааг өгнө.


Хэн оролцох вэ? (Хоршоо болон хоршооны гишүүдтэй харилцдаг оролцогч талууд хэн байх вэ?) (15 минут)

Оролцогчид хоршооны орчинд өөртэй нь харилцдаг бүх оролцогчдыг жагсаан бичнэ (малчин, тариаланч, нийлүүлэгч, худалдан авагч, тээвэрлэгч, зээл олгогч, өрсөлдөгч, төрийн болон судалгааны байгууллагууд, бусад үйлчилгээ үзүүлэгчид).

Зураг 2. Оролцогчдын нэртэй карт бүхий зураглал⁷




⁷ Дээрх жишээг Эвашифрийн боловсруулсан сүлжээний зураглал хийх аргаас авсан ба "Арилжааны бус зорилгоор ашиглах эрхийн 3.0 лицензтэй. Эх сурвалж: <http://netmap.wordpress.com/about/> (2011.10.22)



Тэдний зорилго юу вэ? (15 минут)

Оролцогч хоорондын холбоо ба нөлөөллийг зурагласны дараа тэдний зорилгыг мэдэх нь маш чухал. Тэдний зорилгыг зурагласнаар оролцогчийг аль зүг рүү шилжихийг хүсч байгааг мэдэж болно. Хамтрагч нэг бүрт онцгой анхааран дэмжигч оролцогчийн зорилгыг зураглахыг хичээгээрэй. Энэ зураглалыг хийх явцдаа товчилсон үг, тэмдэг тэмдэглэгээ ашиглаж болно. Зураглалд хүссэн хэмжээгээрээ аль болох нарийвчилсан мэдээллийг оруулаарай. Доорх зурагт хамгаалах (Ха) болон хөгжүүлэх (Хө) зорилгуудыг ялгахад хэцүү учраас маргаан үүсч болзошгүй. Магадгүй бид энэ зургийг оролцогчдын өөр өөр зорилготой байх баримтаар баяжуулж болно.



Дүгнэлт (30 минут)

Бүлэг бодит жишээ, дээрх судалгаан дээр үндэслэсэн сүлжээний зураглалаа хийж дуусмагц үүнээс гарсан үр дүнгийн талаар хэлэлцүүлэг хийнэ. Хэлэлцүүлэгт тусгагдах асуултууд:

Хоршооны үйл ажиллагаанд хамгийн асуудалтай харилцаа аль нь вэ?

Энэ харилцааг сайжруулахын тулд юу хийж болох вэ?

Хамгийн эрх мэдэлтэй оролцогч тал нь хэн бэ?

Өөр өөр харилцаан дахь хоршоо болон түүний гишүүдийн эрх мэдлийн байр суурийг хоршоо хэрхэн сайжруулах вэ?



Ашиглах материал

- Самбарын цаас
- Бичгийн хавчаар, жижиг модон хавтан
- Харандаа, өнгө өнгийн самбарын үзэг



Хугацаа

1 цаг 30 мин – 2 цаг

1.5 Өртгийн сүлжээний дасгал ажил



Зорилго

Өртгийн сүлжээний тухай ойлголт, өртгийн сүлжээнд хоршоодын гүйцэтгэх үүргийг ойлгох.



Арга зүй

Сургагч багш оролцогч бүрийн мэддэг бүтээгдэхүүнийг сонгож авна. Жишээ нь: Кени улсад угали⁸, Энэтхэгт доса⁹ гэх мэт аль болох боловсруулсан бүтээгдэхүүнийг сонгоно. Бүтээгдэхүүнийг аль болох бодитоор үзүүлээрэй. Тайлбаргүй жүжигчилсэн тоглолт байж болно.

Өртгийн сүлжээний уламжлалт дасгал ажлуудын асуултуудыг тавина. Сургагч багш хоршооны хэтийн төлвийг системтэйгээр нэгтгэж, боломжтой үед нь үүний онцлогийг тодруулж байх нь чухал.

Худалдан авагч:

- Та яагаад энэ бүтээгдэхүүнийг худалдаж авсан бэ, үүнийг юугаар хийдэг вэ?
- Та энэ бүтээгдэхүүнийг хаанаас авсан бэ?
- Яагаад тэндээс худалдаж авсан бэ?
- Өөр газраас худалдаж авах боломжтой юу?

Дараа нь худалдан авагч өмнө нь санаатайгаар бүтээгдэхүүн “худалдан авсан” нөгөө оролцогчоо сонгон заана. Тэгээд тэрхүү “худалдаачин”(жижиглэнгийн худалдаачин, малчид, тариаланчид, бөөний худалдаачин)-аас ярилцлага авна.

Жижиглэнгийн худалдаачин:

- Ямар бүтээгдэхүүн худалдаж авахаа та яаж мэддэг вэ?
- Үйлчлүүлэгчдийн чинь хэрэгцээ шаардлага юу вэ, та түүнийг хэрхэн мэддэг вэ?
- Та бүтээгдэхүүнээ хэзээ худалдаж авсан, хэр хугацаанд хадгалсан бэ?
- Та ямар үнээр худалдаж аваад ямар үнээр зарсан бэ?

Энэ дасгал бүх боломжит сүлжээнд оролцогч нартай ярилцаж дуустал үргэлжилнэ.

Бусад оролцогчдод тавих асуултууд:

8. Угали гэдэг нь зүүн Африкийн хоол (заримдаа сима, симбэ, пошо гэж нэрлэдэг). Эрдэнэ шишийн гурилыг усанд чанаад зуурсан гурил шиг өтгөн овъёосны агшамал юм. Эх сурвалж: <http://en.wikipedia.org/wiki/Ugali> (2011.10.22)
9. Доса гэдэг нь эсгэсэн шарвин эсвэл будааны гурил ба хар хивгээр хийсэн бин. Энэ нь Энэтхэгийн өмнөд мужуудын гол хоол хүнс бөгөөд Шри-ланк, Малайз, Сингапурт тосай хэмээх түгээмэл нэрээр танигдсан. Мьянмарт тошай гэж нэрлэдэг. Эх сурвалж: <http://en.wikipedia.org/wiki/Dosai> (2011.10.22)

Боловсруулагч:

- Та бүтээгдэхүүнээ хаанаас худалдаж авсан, таны чанарын шаардлага юу байсан бэ?
- Та энэ бүтээгдэхүүнээр юу хийдэг вэ?
- Та хэн бэ? Хоршоо юу эсвэл хувийн аж ахуй юу?
- Бүтээгдэхүүнийг үйлдвэртээ хэрхэн авчирсан, тээврийн зардлыг нь хэн төлсөн бэ?
- Бүтээгдэхүүнээ та хэнд борлуулдаг (худалдаалдаг) вэ?
- Та бараа бүтээгдэхүүнээ ямар үнээр худалдаж аваад ямар үнээр зарсан бэ?

Тээвэрлэгч:

- Та хэн бэ? Хоршоо юу эсвэл хувийн аж ахуй юу?
- Өөр ямар үйл ажиллагаа эрхэлдэг вэ? (хадгалах, савлах)
- Бусад худалдан авагчдын тээвэрлэлтийг та хариуцдаг уу?
- Таны зардлыг өсөхөд ямар хүчин зүйлүүд нөлөөлж байна вэ?

Дэлгүүр:

- Та хэн бэ? Хоршоо юу эсвэл хувийн аж ахуй юу?
- Та бүтээгдэхүүнээ хаанаас худалдаж авдаг вэ, таны чанарын шаардлага юу вэ?
- Таны үйлчлүүлэгч хэн бэ, тэдний хэрэгцээг та хэрхэн мэддэг вэ?
- Бүтээгдэхүүнээ дэлгүүртээ яаж авч ирдэг вэ?
- Та бүтээгдэхүүнээ ямар үнээр худалдаж аваад ямар үнээр зардаг вэ?

Үйлдвэрлэгч:

- Та хэн бэ? Хоршоо юу эсвэл хувийн аж ахуй юу?
- Та ХАА-н үйлдвэрлэлийн орцоо хаанаас авдаг вэ?
- Та зээл авч байсан уу, танд зээлийг хэн санал болгодог вэ?
- Та өөр үйлчилгээ авдаг уу?
- Бүтээгдэхүүнээ хаана зардаг вэ, яагаад ?
- Таны үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн хэрхэн сайжирч байна вэ, мөн тулгарч буй ямар бэрхшээл байна вэ? (шинэ бордоо, ган гачиг)

Бөөний худалдаачин:

- Та хэн бэ? Хоршоо юу эсвэл хувийн аж ахуй юу?
- Та бүтээгдэхүүнээ яаж сонгож авдаг вэ, таны чанарын шаардлага юу вэ?

- Таны үйлчлүүлэгчийн хэрэгцээ юу вэ, та түүнийг хэрхэн мэддэг вэ?
- Та бүтээгдэхүүнээ хэр хүрэлцээтэй ханган нийлүүлдэг вэ?
- Та бүтээгдэхүүнээ хэзээ худалдаж аваад хэр хугацаагаар хадгалдаг вэ?
- Бараа бүтээгдэхүүн чинь алдагдах юм уу эсвэл муудаж байсан уу?
- Та бараа бүтээгдэхүүнээ ямар үнээр худалдаж аваад ямар үнээр зардаг вэ?

Эцэст нь сургагч багш хоршооны үйл ажиллагаа, гадны үйлчилгээ үзүүлэгчдээс авч байгаа болон өөрийн үзүүлж байгаа үйлчилгээ нь гишүүдийн хэрэгцээнд нийцэж байгаа эсэх талаар цогц дүгнэлт хийнэ.

Нэгдсэн хэлэлцүүлгийн үед сургагч багш өртгийн сүлжээний тухай ойлголтыг үзүүлж тайлбарлан дараах асуултуудын дагуу ярилцана.

- Өртгийн сүлжээнд хоршоо ямар үүрэгтэй вэ? (сүлжээний оператор, сүлжээг дэмжигч, орчныг бүрдүүлэхэд нөлөөлөх) Та ямар нэг жишээ хэлнэ үү?
- Өртгийн сүлжээнд малчид, тариаланчдын эзлэх байр суурийг сайжруулахад хоршоо ямар стратегийг хэрэглэж болох вэ? Та жишээ хэлнэ үү?

Төгсгөлд нь сургагч багш хөгжлийн дөрвөн стратеги тайлбарлана.



Ашиглах материал

Хэвлэмэл картууд



Хугацаа

20-30 минут

1.6: Засаглалын сорилтууд. Оюуны бичиглэлийн дасгал ажил



Зорилго

- Хоршоонд тулгарч болох засаглалын асуудлуудыг шинэлэг байдлаар тодорхойлох



Арга зүй

Буруу зөвийг ялган эргэцүүлэх, хувь хүний зөрчилдөөн, өгөгдсөн хугацаанд зөвхөн нэг оролцогч өөрийгөө илэрхийлэх зэрэг сорилтуудыг оюуны довтолгоо хийж гүйцэтгэх энгийн арга техник юм.

Сургагч багш хоршооны засаглалын сэдвийг танилцуулна (Сэдэв 3).

Энэ товч танилцуулгыг хийсний дараа сургагч багш Модуль 1-д тусгагдсан засаглалын сорилтуудын нэгтэй хамааралтай асуудал бүхий нэг хуудас цаасыг бүх оролцогчдод тарааж өгнө. Үүнд:

- Агентлагийн асуудлууд;
- Үүрэг хариуцлага;
- Оролцоо, хүйсийн харьцаа;
- Ур чадварууд;
- Бие даасан байдал.

Сургагч багш тохирох нэг сорилтыг сонгож нэг бүлэгт өгөөд дараах асуултыг тавина.

- Хоршооныхоо засаглалд эмэгтэйчүүдийн манлайллыг хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Сургагч багш оролцогчдод өгөгдсөн асуудалтай холбоотой хоёр санааг 3 минутад бичих даалгавар өгнө.

Дараа нь оролцогч бүр хуудас цаасаа өөрийн баруун гар талын оролцогчид дамжуулж, зүүн талаас ирсэн цаасан дээр 3 минутад 2 санаа бичих даалгаврыг давтаж гүйцэтгэх ба өмнө бичигдсэн санааг баяжуулах, эсвэл шинээр санаа нэмж бичиж болно. Ингэхдээ өмнө гарсан санааг давтахгүй, аль болох олон шинэ санаа гаргах даалгавар өгөх нь чухал.

Оюуны бичиглэлийн дасгал ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх, эсвэл оролцогчид бүх санаагаа бичиж дуустал үргэлжлүүлэхийг зөвшөөрч болно. Оролцогчид бусдын гаргасан санаатай танилцах үедээ бие даан ажиллах боломжтой, ингэснээрээ энгийн оюуны довтолгооны дасгал ажлын үед гардагаас илүү олон санаа цуглуулж болох юм.

Оюуны бичиглэлийн дасгал ажилласны дараа дүгнэлт хийх нь маш чухал бөгөөд бүлгээрээ нийт хичнээн санаа цуглуулснаа харах боломжтой.



Ашиглах материал

- Оролцогч тус бүрт хуудас цаас
- Харандаа



Хугацаа

15-30 минут

Модуль 2: Хоршооны үзүүлэх үйлчилгээ

2.1: Хэрэгцээг тодорхойлох. Ялгаатай арга хэрэгслүүдийн эвлүүлгийн арга



Зорилго

- Хоршооны гишүүдийн хэрэгцээг тодорхойлох олон аргуудаас суралцах;
- Хэрэгцээг тодорхойлох эдгээр аргуудын давуу ба сул талуудыг ялгах;
- Хоршоонд хэрэглэж болохуйц хэрэгцээг тодорхойлох аргуудыг сонгох чадвартай болох.



Арга зүй

Энэ үйл ажиллагаанд сургагч багш эвлүүлгийн дасгалыг ашиглаж болно. Энэ нь хүмүүсийг өөрийнхөө ойлголтыг хөгжүүлэх, дараа нь мэдлэгээ нийт бүлэгтээ хуваалцахыг дэмждэг хоршооны сургалтын стратеги юм.

Сургагч багш өөр өөр хоршоодод ашиглагдаж байгаа болон ашиглаж болохуйц дараах хэрэгцээг тодорхойлох арга нэг бүрийн талаарх мэдээллийг бэлтгэнэ. Эдгээрт:

- Албан ёсны судалгаа;
- Албан бус судалгаа (хагас бүтэцчилэгдсэн ярилцлагын арга);
- Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг;
- Оролцогчдын ажиглалт ба ярилцлага.

Эдгээр аргууд нь тодорхойлолт, бодит жишээ, бусад холбогдох эх сурвалжуудтайгаа байвал илүү сайн. Сургагч багш оролцогчдыг дөрвөн хүнтэй бүлэгт хуваана. Бүлэг бүрт дөрвөн өөр төрлийн эвлүүлдэг тоглоомын хэсэг өгөх ба бүлгийн гишүүн бүр тодорхой нэг арга дээр ажиллана.

Уншиж дүгнэх цаг (30 минут)

Оролцогч бүр өөрт оногдсон аргын тухай материалыг мөн доорх чиглүүлэх асуултуудыг анхааралтай уншина.

- Энэ арга техник нь юуны тухай вэ? (тодорхойлолт)
- Энэ аргын давуу ба сул тал юу вэ?
- Танд энэ аргыг ашиглаж байсан туршлага бий юу? Та өөрөө энэ аргыг ашиглаж байсан уу? Танай хоршоонд энэ арга тохиромжтой гэдгийг та хаанаас олж мэдсэн бэ?

Эвлүүлгийн хэсгүүдийг солилцох (30 минут)

Жижиг бүлгээр оролцогчид дээрх гурван чиглүүлэгч асуултын хариултын дүгнэлтийг нөгөө бүлгийн гишүүдэд өгнө. Оролцогч бүр тухайн аргын талаарх өөрийн туршлагыг бүлэгт нэмэрнэ. Энэхүү мэдлэг солилцох дасгалаар гишүүдийн хэрэгцээг тодорхойлоход хамааралтай хэрэгцээг тодорхойлох арга хэрэгслүүдэд бүлэг суралцана. Бүлэг бүрийн эцсийн дүгнэлтийг самбарын цаасанд тэмдэглэж төгсгөлийн дүгнэлт хэсэгт ашиглана.

Төгсгөлийн дүгнэлт хэсэг (15-30 минут)

Бүх оролцогчдыг хамруулсан төгсгөлийн дүгнэлт хэсэгт сургагч багш хэрэгцээг үнэлэхэд тохирох аргуудыг сонгосон хүснэгтийг оролцогчдод үзүүлнэ (Сэдэв 1. Хүснэгт 1.2).



Ашиглах материал

- Хэрэгцээг тодорхойлох төрөл бүрийн арга хэрэгслүүдийн танилцуулга
- Оролцогч бүрт цаас, үзэг

Нэмэлт хувилбар

Хэрвээ сургагч багш хэрэгцээг тодорхойлох төрөл бүрийн аргуудын талаар урьдчилан материал бэлтгээгүй тохиолдолд дасгал ажлыг оролцогчдын өмнөх туршлага дээр тулгуурлан шууд эхэлж болно. Сургагч багш бүх оролцогчдыг бичил бүлэгт хувааж дараах асуултуудыг тавина.

- Гишүүдийнхээ хэрэгцээг хэрхэн тодорхойлдог вэ?
- Эдгээр хэрэгцээг тодорхойлоход ямар арга хэрэгслийг ашигласан бэ?
- Эдгээр аргуудын давуу ба сул талууд юу вэ?

Дараа нь нэгдсэн хэлэлцүүлгээр бүлгүүд өөрт ноогдсон арга, хэрэгслүүдийн талаар танилцуулж сургагч багш самбарын цаасан дээр бичнэ. Хэлэлцүүлэг нь дараах хоёр асуултын дагуу явагдана.

- Тодорхойлж гаргасан хэрэгцээнүүд нь хоршооны бизнесийн гол үйл ажиллагаатай тогтмол уялддаг уу? Хэрвээ үгүй бол юу хийдэг вэ?
- Тодорхойлж гаргасан хэрэгцээнд нь гишүүдийн олонхийн хэрэгцээ тусгагдсан уу? Үгүй бол юу хийдэг вэ?



Хугацаа

1 цаг 30 мин

2.2: Оюуны зураглал ба хэрэгцээг эрэмбэлж + үйлчилгээтэй холбох дасгал ажил



Зорилго

- Гишүүдийн хэрэгцээг тусгах;
- Гишүүдийн хэрэгцээг эрэмбэлж сургах.



Арга зүй

Хэрэгцээг зураглах (20 минут)

Оролцогчид багштай хамтран оюуны зураглалаа гаргана. Зураглалын голд нь сургагч багш “гишүүдийн хэрэгцээ” гэж бичээд оюуны довтолгооны аргаар оролцогчид өөрсдийн хоршооны туршлагаас үндэслэн ялгаатай хэрэгцээнүүдээ тодорхойлно. Оролцогчид бүгд нэг хоршооны гишүүд байгаа тохиолдолд энэ арга илүү сонирхолтой байдаг. Харин оролцогчид өөр өөр хоршооноос оролцож байгаа бол тус тусдаа бүлгээр ажиллаж болно.

Хэрэгцээг эрэмбэлэх (20 минут)

Хэрэгцээг тодорхойлох эхний бүртгэлийн дараа сургагч багш оролцогч бүрт дараах асуултууд бүхий хуудас цаасыг тарааж өгнө. Үүнд:

- Бусад үйлчилгээ үзүүлэгчид хэрэгцээг хангадаг уу?
- Бүтээмжийг нэмэгдүүлэхэд хэрэгцээг хангах нь хэр чухал вэ?
- Энэ хэрэгцээ нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулахтай хэр нийцдэг вэ?
- Орон нутгийн хомсдлыг арилгах чиглэлээр ямар хэрэгцээг өргөжүүлэх ёстой вэ?
- Эдгээр хэрэгцээнүүд нь хоршооны бизнесийн гол үйл ажиллагаатай хамааралтай байна уу?
- Тулгарч буй саадад хэрэгцээ тусгагдсан уу?

Сургагч багш эдгээр асуултуудыг тайлбарлаж, оролцогчдыг оюуны зураглал дээр цуглуулсан хэрэгцээнүүдээ дахин сэргээн санаж эргэцүүлэхийг даалгана. Сургагч багш оролцогч тус бүрт гурван ширхэг од өгч хамгийн чухал гэж үзсэн хэрэгцээн дээрээ одоо байрлуулах даалгавар өгнө. Энэ эрэмбэлэх дасгалын дараа олон од наасан нэн чухал хэрэгцээг бид харах болно.

Дүгнэлт (20 минут)

Хамгийн олон од наасан хэрэгцээг үндэслэн сургагч багш төлөвлөлтийн ач холбогдол дээр суурилсан хэлэлцүүлгийг эхлүүлнэ. Энэ хэлэлцүүлгийг төлөвлөлтийн аргуудын хүчтэй нөлөөг харуулсан бодит жишээ болох Чили улсын хөдөөгийн хөгжил бизнесийн байгууллагын туршлагаар баяжуулж болно (Сэдэв 2. Бодит жишээ 2.1).

Хэрэгцээг үйлчилгээтэй холбох нь (20 минут)

Оролцогчид хоршооны орчинд үзүүлэх боломжтой дэмжих үйлчилгээнүүдийг жагсаан бичнэ.

- Үйлдвэрлэлийн үйлчилгээ (улбар шар өнгийн цавуутай цаас);
- Маркетингийн үйлчилгээ (ногоон өнгийн цавуутай цаас);

- Бизнес менежментийн үйлчилгээ (хөх өнгийн цавуутай цаас);
- Санхүүгийн үйлчилгээ (шар өнгийн цавуутай цаас);
- Өртөг шингэсэн үйлчилгээ (ягаан өнгийн цавуутай цаас).

Үйлчилгээний төрөл тус бүрт хэд хэдэн наалддаг цаас наана. Боломжит үйлчилгээнүүдийн жагсаалтыг гаргасны дараа эдгээр үйлчилгээнүүдийг өмнө тодорхойлсон хэрэгцээтэйгээ холбох даалгаврыг оролцогчдод өгнө.

Төгсгөлийн хэлэлцүүлэг (15 минут)

Сургагч багш төгсгөлийн хэлэлцүүлгийг хоршоо ямар үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар явуулна. Хэлэлцүүлгийг доорх асуултын дагуу явуулж болно:

- Гишүүдэд үзүүлж буй үйлчилгээ нь хоршооны зорилго, стратегид дэмжлэг болдог уу?
- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйлчилгээний үр дүн нь зах зээлийн эрэлтэнд нийцэж байна уу?
- Үйлчилгээг хэрхэн хүргэх вэ? 1-рт шууд хоршоогоор, 2-рт гадны бусад хүмүүсээр, 3-рт зах зээлд бие даасан үйлчилгээ үзүүлэгчийг үйлдвэрлэгч нар өөрсдөө сонгох гэсэн гурван хувилбараар үзүүлж болно.

Хичээлийг дүгнэхдээ сургагч багш оролцогч нарт үйлчилгээний зах зээлд дүн шинжилгээ хийхэд зайлшгүй мэдэх шаардлагатай гурван бүрэлдэхүүн хэсгийг (эрэлт, гүйлгээ, нийлүүлэлт) танилцуулж, эдгээр гурван бүрэлдэхүүнийг судлахад оролцогчдод тусалж чадах жишээ асуултууд тавина (Сэдэв 3. Хүснэгт 3.1).



Ашиглах материал

- Оюуны зураглал зурахад зориулсан самбарын цаас
- Харандаа
- Однууд
- Цавуутай өнгийн цаас



Хугацаа

1 цаг 30 минут-1 цаг 45 минут

2.3: Давуу болон сул тал, боломж аюул, нөхцөл байдлын шинжилгээ. Хоршоо гишүүддээ үйлчилгээ үзүүлэхийн тулд чадавхиа хэрхэн сайжруулах вэ?



Зорилго

Хоршооны үйлчилгээ үзүүлэх дотоод чадварыг үнэлэхэд суралцах.



Арга зүй

Хоршооны давуу тал, сул тал, аюул, боломжийг хэрхэн дүгнэх талаарх ойлголтыг сургагч багш тайлбарлана. Сургагч багш нөхцөл байдлын шинжилгээний өөр хоорондоо ялгаатай бүрэлдэхүүнүүдийг нарийвчлан тайлбарлана.¹⁰

Нөхцөл байдлын шинжилгээ



Үүний дараа нөхцөл байдлын шинжилгээний элементүүдийг хоршооны нөхцөл байдалд тайлбарлана. Үүний тулд сургагч багш дараах нэмэлт зааварчилгааг өгч болно. Үүнд:

- Давуу ба сул тал нь дотоод хүчин зүйлс бөгөөд гишүүддээ дэмжих үйлчилгээ үзүүлэх хоршооны чадавхийг дээшлүүлэхэд ашиглана.
- Давуу тал нь дотоод нөөц бололцоог харуулдаг. Хоршоо нь гишүүддээ үйлчилгээ үзүүлэх чадавхиа сайжруулахын тулд давуу талаа үр дүнтэйгээр ашиглах ёстой. Жишээлбэл, гишүүддээ үйлдвэрлэлийг нь дэмжих үйлчилгээг үзүүлэхдээ хоршоо өөрийн мэргэшсэн, чадварлаг ажилтнуудаа ашиглаж болно.
- Сул тал нь хоршооны гишүүддээ үйлчилгээ үзүүлэх чадавхийг бууруулдаг. Үйлчилгээ үзүүлэх чадавхиа сайжруулахын тулд хоршоо сул талаа арилгах арга замыг олох ёстой.
- Хэрвээ сул тал нь ажилчдын ур чадваргүй байдалтай холбоотой бол хоршоо гишүүддээ үзүүлэх үйлчилгээний чадавхийг сайжруулахын тулд ажилчиддаа зориулж холбогдох сургалтыг зохион байгуулж болно.

¹⁰ ОУХБ- Африкийн хоршоо : төсөл бичих гарын авлага: хоршоо болон бусад өөртөө туслах байгууллагуудын хөгжлийг дэмжих "алхам алхамын арга" (Женев, 2010) <http://www.ilo.org/public/english/employment/ent/coop/africa/download/coopafriaprojectdesignmanual.pdf> (2011.10.22).

- Боломж нь хоршооны үйлчилгээ үзүүлэх чадавхийг сайжруулахад давуу тал болон ашиглагдах гадаад эерэг хүчин зүйл юм. Жишээлбэл, хоршоо судалгааны үр дүнг авч малчид, тариаланчдын ХАА-н үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан түгээхэд судалгааны төвийг давуу талаа болгон ашиглаж болно.
- Нөхцөл байдлын шинжилгээ нь үйлчилгээг шууд үзүүлэхэд хоршооны зарим үйлчилгээнүүд харьцангуй давуу талтай эсвэл сул талтай болохыг улам тодорхой болгож өгдөг.

Энэ тайлбарын дараа оролцогчдод дараах арга зүйг тайлбарлана.

Оролцогчдыг дөрвөн бүлэгт хувааж, бүлэг бүр хоршооны бодит жишээ сонгож тодорхой нэг үйлчилгээнд илүү анхаарч ажиллана. Бүлэг энэхүү бодит жишээн дээр нөхцөл байдлын шинжилгээг иж бүрнээр хийнэ. Энэ шинжилгээг зөвхөн нэг үйлчилгээн дээр хийхийг онцлон анхааруулна. Бүлэг сул тал ба аюулыг шийдвэрлэхүйц бодит, хэрэгжүүлж болохуйц стратеги буюу үйл ажиллагааг бодож олох хэрэгтэй болно.

Үүний тулд дараах асуултуудыг асууна.

- Хоршоо гишүүддээ үзүүлж байгаа үйлчилгээнээс нэгийг сонгоно уу?
- Энэ үйлчилгээг хэрэгжүүлэх хоршооны нөхцөл байдлын шинжилгээг хийнэ үү?
- Үйлчилгээг сайжруулахын тулд нөхцөл байдлын шинжилгээнд тулгуурлан ямар бодит үйл ажиллагаануудыг хэрэгжүүлж болох вэ?

Хэсэг хугацааны дараа бүлгүүд нөхцөл байдлын шинжилгээний үр дүнгээ танилцуулж, хамгийн чухал 5 үйл явцыг тодорхойлно.



Ашиглах материал

- 4 ширхэг самбарын цаас;
- Харандаа, самбарын үзэг.



Хугацаа

1 цаг 15 минут-1цаг 30 минут

Модуль 3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт

3.1: Бие биедээ туслах арга ашиглан тодорхой сорилтуудыг шийдвэрлэх нь



Зорилго

- ХАА-н үйлдвэрлэлийн орцыг нийлүүлэхтэй холбоотой сорилтуудыг даван туулахад суралцах.



Арга зүй

Энэ хичээлээр мэдлэг туршлагатай хүмүүсийн тусламжтайгаар бэрхшээлийг шийдвэрлэх аргыг, өөрөөр хэлбэл тэдгээр хүмүүсийн мэдлэг, туршлагыг ашиглана гэсэн үг юм. Энэ нь тодорхой бэрхшээлийг орчинд нь тохирсон шийдлээр арилгахад зориулагдсан юм.

Сургагч багш оролцогчдод тулгарч байсан сорилтууд, эсвэл сонирхолтой бодит түүхийг урьдчилан бэлтгэсэн байх хэрэгтэй. Модуль 3 (тухайлбал Сэдэв 1. Бодит жишээ 1.1: Увс аймгийн “Ногоон худаг” хоршоо) шинэ үйлчилгээг хэрхэн эрсдэлгүй нэвтрүүлсэн зарим боломжит жишээг өгч болно:

- Гишүүддээ шинэ үйлчилгээг үзүүлэхэд эрсдэл, сорилтууд тулгардаг. Шинэ хөрөнгө оруулалт эсвэл үйлчилгээ хэрэгжих боломжтой үгүйг та хэрхэн мэдэх вэ?
- Их хэмжээний худалдан авалт хийхэд хоршооны санхүүд эрсдэл, сорилтууд учирдаг. Их хэмжээгээр худалдан авалт хийхэд хөрөнгө хүрэлцэхгүй бол та ямар арга хэмжээ авах вэ?
- Үзүүлэх үйлчилгээг зохион байгуулахтай холбоотой гишүүдийн дундах ойлголтуудын ялгааг хэрхэн шийдвэрлэх вэ?

Сургагч багш оролцогчдын дунд 3-4 бодит жишээг танилцуулж, хэн нь эдгээр сорилтын талаар мэддэг эсэхийг асууж туслагчаар ажиллахыг хүснэ. Энэ сургалтын аргатай¹¹ танилцахын тулд оролцогчид оршил болгож доорх киног үзэж болно.

Туслагч багш нь тодорхойлогдсон сорилтуудыг бүлэгт танилцуулна. Ингэхдээ тогтсон уламжлалт танилцуулгаар биш шаардлагатай мэдээллийг цагийн хуваарьтай багтаан 7-10 минутанд багтаан танилцуулна. Бодит жишээ эсвэл сорилтуудыг самбарын цаасан дээр (нэгтгэн дүгнэсэн эсвэл оюуны зураглал шиг) зурж харуулж болно. Танилцуулгын дараа бүлэг бодит жишээнд гүн гүнзгий шинжилгээг хамтдаа хийх сургагч багшийг сонгоно. Туслах багш нь хэлэлцүүлгийг ажиглаж, сонсож хэлэлцүүлгийн үндсэн мэдээллийг хэвээр хадгална. Сургагч багш бүлгээс гарсан бүх саналуудыг дэмжиж хэлэлцүүлгийн үйл явцыг самбарын цаасан дээр буулгана. Энэ үйл ажиллагаа нь 45 минут үргэлжлэх бөгөөд энэ хугацаанд бүлэг бүх саналууд болон гол дүгнэлтээ гаргасан байна.

¹¹ Бие биедээ туслах арга, <http://www.youtube.com/watch?v=ObmQyW3EiiE> (2011.10.22).

Хувилбар: Туслагчийг ээлжлэн солих

Эхний туслагчтай хамтран ажилласны дараа оролцогчдын бүлэг дараагийн туслагч руу очно. Туслах багш болон сургагч багш нар байрандаа үлдэж шинээр ирэх бүлгийг угтаж авна.

Бүлгүүд өөрсдийн бэрхшээлүүдийг шийдвэрлэж дууссаны дараа бүлгүүд нэгдсэн хэлэлцүүлэгт нэгдэж сургагч багш бусад туслагч нарыг хамтарсан дүгнэлт дүгнэлтийг хийхээр дуудна. Энд сургагч багш бүр гол санаа, ойлголтуудыг талаар нэгтгэлээ танилцуулна.



Ашиглах материал

- Тодорхойлж гаргасан тулгамдаж буй асуудлын тоогоор самбарын цаас;
- Харандаа, самбарын үзэг;
- Бие биедээ туслах аргын тухай видео бичлэг.



Хугацаа

1 цаг 30 мин -2 цаг

3.2: Агуулах ба нөөцийн удирдлага “Өртөөчилсөн аялал” дасгал ажил



Зорилго

Хадгалалтын давуу ба сул талыг судлах.



Арга зүй

Нөөцийн удирлагатай холбоотой өөр өөр сэдвийг хурдтай бөгөөд эрчимтэй хэлэлцэхийн тулд “өртөөчилсөн аялал” дасгалын аргыг энэ хичээлээр танилцуулна.

Сургагч багш доорх хэлэлцүүлгийн сэдвүүдийг тодорхойлж өрөөний булангуудад сэдэв бүрийг байрлуулна.

I үе (50 минут)

Давуу тал ба сул тал

Сэдэв 1. Хадгалалт;

Сэдэв 2. Өөрийн унаагаар тээвэрлэх;

Сэдэв 3. Их, бага хэмжээтэй нөөц;

Сэдэв 4. Төвлөрсөн ба төвлөрсөн бус нөөц.

Булан бүрт самбарын цаас, самбар, бичгийн хэрэгслүүд болон хагас тойрог хэлбэрээр зассан сандалнууд байна.

Оролцогчид булан бүрт 10 минут зарцуулна. I үеийн эхний 5 минутад оролцогчдыг ярихыг хориглоно. Тэд өөрсдийн санаагаа бусад оролцогчидтой санал солилцохгүйгээр шууд бичнэ. Сургагч багш хонх дуугаргаж оролцогчдыг дараагийн буланд очихыг сануулна. Оролцогчид өмнө гарсан санаануудыг баяжуулах, зөв болгож засах, нарийвчлах, жишээ гаргах гэх зэргээр нэмж болно.

II үе (15 минут)

Хамтын хэлэлцүүлэг

Таван удаагийн тойргийн дараа оролцогчид сандлаа арагш татаж эцсийн саналуудаа тусган бичсэн самбарын цаасаа аваад нэг том тойрог үүсгэнэ. Бүлгүүд 3 минутанд багтаан ажлын үр дүнгээ танилцуулна. Ингэхдээ бүлгүүд хамгийн сүүлийн буланд тэмдэглэсэн цаасан дээрх саналуудыг танилцуулна.

III үе (25 минут)

Төгсгөлийн хэлэлцүүлэг

Сургагч багш дээрх 4 сэдвийн сул ба давуу тал дээр үндэслэн ХАА-н үйлдвэрлэлийн орцын ханган нийлүүлэлтийн (хоршоо шууд гишүүддээ тараах уу, гадны нөөц ашиглах уу, эсвэл гишүүдийг өөрсдөөр нь ханган нийлүүлэлтийн байгууллагыг сонгуулах уу) талаар хоршооны менежерүүд хэрхэн оновчтой шийдвэрийг гаргаж болох тухай төгсгөлийн хэлэлцүүлгийг эхлүүлнэ. Нэгдсэн хэлэлцүүлгийн үед оролцогчид менежерүүдэд шийдвэр гаргахад нь зориулж саналаа хэлнэ. Жишээ нь: зардал-үр ашгийн тооцоо, гишүүдийн хэрэгцээг тодорхойлох, эрсдлийн шинжилгээ, тухайн салбарын бусад үйлчилгээ үзүүлэгчдийн талаарх дүн шинжилгээ эсвэл хүрээлэн буй орчны нөлөөлөл гэх мэт.



Ашиглах материал

- 5 ширхэг самбарын цаас;
- Харандаа, самбарын үзэг;
- Тойрог хэлбэрээр зассан сандлууд.



Хугацаа

1 цаг 30 мин

3.3: Үнийн бодлого боловсруулах. Шинжээч нарын мэтгэлцээний дасгал ажил



Зорилго

- Үнийн бодлого тодорхойлж сурах;
- Үнийн стратеги сонгох;
- Үнийн бодлогыг боловсронгуй болгож, тохируулах.



Арга зүй

Алхам 1 (45 минут)

Сургагч багш үнийн бодлого төлөвлөлтийн 3-4 шинжээч эсвэл туршлагатай оролцогчдыг урьдчилан урина. Шинжээч нар хэлэлцүүлгээр хэлэлцэх цуврал асуултуудыг урьдчилан хүлээж авна.

- Танай хоршооны үнийн бодлого юу вэ? Шалтгааныг тайлбарлана уу?
- Танай хоршооны үнийн стратеги юу вэ? Үүнийг та бүхэн хэрхэн шийдсэн бэ?
- Танай хоршоо хэрхэн үнийн зөв бодлогыг тохируулан хэрэгжүүлсэн бэ? Энэ талаар өгөх зөвлөгөө танд байна уу?

Хэлэлцүүлэгт зориулсан зөвлөгөө:

- Тухайн сэдэв болон түүний олон төрөлт төлөв байдлыг танилцуулж чадах туршлагатай, шинжээч болон илтгэгчийг тодорхойлох;
- Шинжээч нартай хэлэлцэх асуудал, хэлбэр, зохион байгуулалтын асуудлыг
- урьдчилан тохирно. Шинжээчдийг хэлэлцүүлэгт бэлдэхэд нь тусалж бэлтгэлийн үйл явцыг тогтмол шалгах;
- Хэлэлцүүлгийн үүрэг, үйл явц, гарах үр дүнг тодруулахын тулд хичээл эхлэхээс өмнө шинжээч нартай товч мэдээлэл солилцох;
- Сэдвийн агуулга болон хэмжигдэхүүнийг илэрхийлэх асуултуудаар шинжээчдийн хэлэлцүүлгийг нээх;
- Шинжээч нарт хариулт өгөх хангалттай хугацааг олгох ба хэрэв хариулт нь өөр тийшээ хазайсан тохиолдолд зогсоох;
- Шаардлагатай бол шинжээч нарыг урьдчилан бэлдсэн асуултууд руу оруулж хэлэлцүүлгийг дахин чиглүүлэх, тэднийг өөрсдийн санал бодлоо илүү тодорхой болгохыг хүсэх;
- Хэрэв хэлэлцүүлэг төлөвлөснөөс өөр болох тохиолдолд үүнийг үр дүнтэй болгохын тулд жагсаалтанд байхгүй асуултуудыг санаачлан зохиох.

Энэхүү хэлэлцүүлэг, ялгаатай асуултууд болон эдгээр нь Модуль 3-тай хэрхэн холбогдож байгаа талаар танилцуулах нь сургагч багшийн үүрэг юм. Нэгдсэн дүгнэлтийн явцад сургагч багш шинжээчийн гаргасан саналыг үнийн бодлого боловсруулах шат бүртэй холбох нь маш чухал юм.

Алхам 2 (45 минут)

Сургагч багш бүлгийн оролцогчдыг цавуутай том цаасан дээр үнэд нөлөөлөх гадаад болон дотоод ямар хүчин зүйлүүд байдгийг бичих даалгавар өгнө.

Эхний оюуны довтолгоо дасгалаар дараах хүчин зүйлсүүд гарч ирнэ:

Үнэ - бүтээгдэхүүний эрэлт-өрсөлдөөн-үйлдвэрлэлийн дундаж - холбогдох хууль эрх зүй- үйлчлүүлэгчийн хүлээлт-туршлага.

Хүчин зүйлс тус бүрийг оролцогчдоор өөрсдөөр нь тайлбарлуулна. Энд гарч ирсэн тайлбарт үндэслэн сургагч багш хэрэгцээтэй болон нэмж тодруулах зүйлсийг тайлбарлана (Сэдэв 3. Хүснэгт 3.3).

Төгсгөлийн дүгнэлт (15 минут)

Хичээлийн явцад олж авсан хамгийн гол санаануудыг нэгтгэн дүгнэсэн байх ёстой. Хэрвээ цаг хүрэлцээтэй байвал зарим нэмэлт асуултуудыг асууж болно. Үүнд:

- Эрсдлийг та хэрхэн зохицуулдаг вэ?
- Нийлүүлэлтийн санхүүгийн үйл ажиллагааг та хэрхэн хэмждэг вэ?



Ашиглах материал

- Цавуутай том цаас;
- Самбарын үзэг, харандаа;
- Хавсралт 1 дэх хүснэгтийг оролцогч тус бүрт хэвлэн тараах.



Хугацаа

1 цаг 30 минут-2 цаг

Модуль 4. Хоршооны маркетинг

4.1: Өртгийн сүлжээний бодит жишээ



Зорилго

- Өртгийн сүлжээний талаарх ойлголтоо бодит жишээгээр бататгах;
- Зах зээлийн шаардлага болон өртгийн сүлжээний үр нөлөөг үнэлэх.



Арга зүй

Сургагч багш дараах жишээг танилцуулна:

Нигер улсын "Квалигийн тахиа үржүүлэгч, борлуулагчдын хоршоо" нийслэл Абужа хотын зах зээлд тахиагаа борлуулдаг. Тахиан аж ахуй эрхлэгч нар тахиагаа нийлүүлээд амьдаар нь зарахад ганцаараа тахиагаа зарснаас арай илүү үнэд хүрдэг байна. Улирлын байдлаас шалтгаалан худалдаачид нэг тахиаг 850-1100 Найра(мөнгөн тэмдэгт)-гаар худалдан авдаг. Абужа хотын хэрэглэгч нар ясгүй тахианы цээж махыг орон нутгийн дэлгүүрээс 750 найрагаар худалдан авдаг. Тахианы цээж мах ойролцоогоор 125 гр байдаг.

Сургагч багш оролцогчдоос Абужа хотын хэрэглэгчдэд шаардлагатай байгаа тахианы ясгүй цээж махны өртгийн сүлжээний зураглалыг хийх даалгавар өнгө.

- Хэрэглэгчдийн тавьж буй чанарын шаардлага юу вэ?

Бүлгүүд өртгийн сүлжээн дээр ажиллана.

45 минутын дараа сургагч багш бүлгүүдэд бодит жишээг баяжуулсан нэмэлт даалгавар өгнө.

"2011 оны зул сарын баяраар Абужа хотын Ширатон буудалд нэг бүр нь 150 гр 12000 ширхэг тахианы ясгүй цээж мах хэрэгтэй болсон. Тахианы махыг шинэ, органик, эм тариа тариулаагүй байх шаардлага тавив. Уг зочид буудал тахианы нэг цээж маханд 1000 найра төлөхийг хүссэн. Зочид буудал бүх тахиагаа нэг хоршооноос авахыг хүссэн. Танай хоршоо гишүүдийнхээ орлогыг нэмэгдүүлэх боломж гарсан учир энэ тахиаг нийлүүлэхийг сонирхсон."

Бүлгүүдэд өөр өөр даалгавар өгнө.

1, 2-р бүлэгт

- Чанарын шаардлагыг хангах болон бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулахад хоршоо юу хийж чадах вэ?

3,4-р бүлэгт

- Хоршоо зардлаа бууруулж, бүтээмжээ дээшлүүлэхэд юу хийж чадах вэ?

5-р бүлэгт

- Тахианы аж ахуйн эрхлэгчид хувиараа болон хамтдаа ямар шинэ үүрэг хүлээж байна вэ?



Зөвлөгөө

Өртгийн сүлжээний талаар ойлголтгүй оролцогч нарт Модуль 1-т гарсан өртгийн сүлжээний дасгал ажлыг санал болгоно.



Ашиглах материал

- Самбарын цаас;
- Харандаа;
- Бодит жишээ бүхий тараах материал.



Хугацаа

1 цаг 30 минут

4.2: Зах зээлийн мэдээлэл: Хоршооны шинжилгээ



Зорилго

Хоршоонд зах зээлийн ямар төрлийн мэдээлэл хэрэгтэй болох талаар дүн шинжилгээ хийх.



Арга зүй

Танилцуулга (15 минут)

Сургагч багш зах зээлийн мэдээллийн чухлыг харуулсан богино танилцуулга/пресэнтаци/-аар сургалтыг эхлэнэ. Энэхүү танилцуулгаар сургагч багш доорх зүйлсийг танилцуулна:

- Зах зээлийн ямар төрлийн мэдээлэл хоршоонд хэрэгтэй вэ?
- Мэдээллийг хэрхэн боловсруулах вэ?

Бүлгийн ажил (1 цаг)

Сургагч багш бүлгийг 4-6 гишүүнтэй дэд бүлэгт хуваана. Бүлэг бүр доорх асуултуудын оновчтой хариултыг гаргаж хариултаа хүснэгтээр дээр харуулна.

Хэрэглэгчийн шинжилгээ:

- Танай хоршооны бүтээгдэхүүнийг хэрэглэдэг хэрэглэгчдийн ялгаатай төрлүүдийг тодорхойлох;
- Тэдний эрэлт, хэрэгцээний талаар та юу мэдэж байна вэ? (тоо хэмжээ, чанар, үнэ, цаг хугацаа, сав баглаа боодол гэх мэт);
- Та худалдан авагчийн (эцсийн хэрэглэгч) эрэлтийн талаар юу мэдэх вэ?
- Ойрын ирээдүйд таны хэрэглэгчийн хэрэгцээнд ямар өөрчлөлт гарахыг та урьдчилан мэдэж чадах уу?
- Дээрх хариултуудыг авахын тулд та ямар аргыг хэрэглэж байна вэ?

Өрсөлдөгчийн шинжилгээ:

- Өрсөлдөгчөө тодорхойлно уу, та тэдний талаар юу мэдэх вэ?
- Танай өрсөлдөгчийн хэрэглэгч хэн бэ?
- Өрсөлдөгч нар тань хэзээ бараагаа зах зээлд борлуулдаг вэ?
- Тэд бараагаа ямар үнээр борлуулдаг вэ?
- Танай өрсөлдөгч нар урамшууллын ямар аргыг ашиглаж байна вэ?
- Тэдний борлуулалтын үйл явц нь ямар байдаг вэ?

ХҮСНЭГТ

Өрсөлдөгчийн нэр	Хэрэглэгч	Тэдний бүтээгдэхүүний чанар	Борлуулалтын хугацаа	Үнэ	Гадаад байдал	Бусад мэдээлэл

Бүлгийн хэлэлцүүлэг (15 минут)

Хийсэн хүснэгтүүдийг танилцуулна.



Ашиглах материал

- Бүлэг бүрт самбарын цаас;
- Харандаа, самбарын үзэг;
- Асуултуудын жагсаалт бүхий хэвлэмэл гарын авлага.



Хугацаа

1 цаг 30 минут

4.3: Үйл ажиллагааг сайжруулах. Шилдэг 100 жагсаалт



Зорилго

- Маркетингийн стратегийн талаар бүтээлч сэтгэхүйг өдөөх;
- Хоршоо болон хоршооны гишүүд илүү таатай нөхцөлтэй гэрээ байгуулахын тулд үйл ажиллагаагаа сайжруулах төрөл бүрийн аргуудыг нээх.



Арга зүй

Хамтын зах зээлд хоршоо оролцохдоо (хоршоо гишүүдийнхээ бүтээгдэхүүнийг худалдаж аваад зах зээлд борлуулах) бүтээгдэхүүнээ нийлүүлж байгаа хоршооны гишүүд, бүтээгдэхүүний эцсийн хэрэглэгч хоёр хоёулаа сэтгэл хангалуун байх ёстой гэдэг ойлголтыг сургагч багш тайлбарлаж өгнө. Хоршоо үйл ажиллагаагаа сайжруулах үед худалдан авагчид илүү өндөр үнэ төлөх, эсвэл илүү ихийг худалдан авч болох юм.

Сорилт: Хоршоо хэрхэн үйл ажиллагаагаа сайжруулах вэ?

Энэхүү сорилтыг самбарын цаасны дээд талд бичнэ.

Бүтээлч оюуны довтолгооны дасгал (1 цаг)

Ханан дээр 1-100 хүртэлх тоонуудыг бичнэ.

Оролцогчдыг өөрсдийн санааг аль болох хурдан гаргах заавар өгнө. Гарсан санаанууд оновчтой бус, бүрхэг, ойлгомжгүй байсан ч хамаагүй бүгдийг тэмдэглэж авна. Мэдээж эхний 30 санаа нь оролцогчдод саяхан тохиолдсон болон тэдний туршлагатай холбоотойгоор өөрсдөө сонгосон санаанууд байх нь ойлгомжтой. Харин дараагийн 40 санаа бол илүү загвар, хандлага руу чиглэсэн байна. Эдгээр санаанууд нь зуршил болсон хандлагаас ялгаатай байхыг шаарддаг учраас гаргахад хэцүү санагдаж магадгүй. Ихэнх нийтлэг санаанууд аль хэдийн цаасан дээр тэмдэглэгдсэн байх учраас төгсгөлийн 30 санаа нь илүү төсөөллийн шинжтэй байна. Энэ нь ирээдүйд тохиолдож болох төлөв байдлын өөрчлөлт учраас үйл ажиллагааны хамгийн үр дүнтэй үе юм.

Бүлгийн хэмжээ, үргэлжлэх хугацаа, цар хүрээ зэргээс хамаарч 100 гэсэн эцсийн тоонд хүрэх нь байнгын сорилт байдаг. Энэ нь оролцогчдын оюуны довтолгооны дасгалаар гарч ирэх санаануудыг тогтоосон тоонд хүргэх хамгийн тохиромжтой арга юм (Семинарын бүхий л хугацаанд жагсаалтыг үргэлжлүүлж болно).

Дүгнэлт хэлэлцүүлэг (30 минут)

Сургагч багш одоо байгаа жагсаалтын үр дүнгийн талаар бүлэгтэй саналаа хуваалцана. Бүлгийн хамтаар сургагч багш жагсаалт дахь өөр өөр ахиц дэвшлийн стратегийг тодорхойлохыг оролдоно:

- Бүтээгдэхүүний ахиц дэвшил
- Боловсруулалтын ахиц дэвшил
- Ажил үүргийн ахиц дэвшил
- Сүлжээ болон сүлжээ хоорондын ахиц дэвшил (төрөлжүүлэлт)

Сургагч багш оролцогч бүрийг хоршоондоо таван бодит жишээтэй буцан очиж хоршооныхоо гишүүд болон менежментийн зөвлөлтэй нарийвчлан хэлэлцэхийг хүснэ.

Зөвлөгөө

- Энэ жагсаалтыг хийхэд хангалттай хугацаа байгаа эсэхийг нягтлаарай, учир нь энэ нь бүрэн хийгдсэнээр үр дүн гарна;
- Бүх хүмүүсийн анхаарлыг сарниулахгүйн тулд өрөөг хоосон болгох хэрэгтэй. Гар утсаа унтрааж, ууж байсан зүйлээ дуусгах гэх мэт;
- Давтагдсан санаанууд нь оролцогчдын бодох үйл явцад сэжүүр болж өгөх магадлалтай. Иймд хичээлийн төгсгөлд түүнд анхаарах нь зүйтэй;
- Үнэт цаг ба эрч хүчээ алдахгүй байхын тулд оролцогчдыг бүтэн өгүүлбэрээр биш, аль болох товчилсон үг, богино өгүүлбэр ашиглахыг сануулах



Ашиглах материал

- Самбарын цаас



Хугацаа

1 цаг 30 минут

4.4: Маркетингийн хольцын хөлөгт тоглоом¹²



Зорилго

- Аль болох олон маркетингийн санаанууд болон бэрхшээлүүдийг илрүүлэх;
- 5Б-г ашиглан оролцогчдын маркетингийн мэдлэгийг дээшлүүлэх.



Арга зүй

I үе (30 минут)

Оролцогчдоос өнөөдрийг хүртэлх хугацаанд маркетингийн талаар юу сурч мэдсэнийг асууна. Тэдний өмнөх мэдлэгийг 5Б буюу бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний үнэ, бүтээгдэхүүний идэвхжүүлэлт, байршил, бүтээгдэхүүнд оролцогч (Сэдэв 2)-той холбож бататгана. 5Б-г харуулсан зурагт хуудас үзүүлнэ.

II үе (60 минут)

Оролцогчдыг 4-6 хүнтэй бүлэг болгон хуваана. Бүлэг бүр тоглоомын идэвхжүүлэгчээ сонгоно. Тоглоомын дүрмийг тайлбарлаж бүх оролцогчдын бүрэн ойлгосон эсэхийг тодруулна. Хүн бүр байраа эзлэн өөр өөр өнгийн чулуу авч хөлгийн эхнээс эцэс хүртэл нэг нүднээс дараагийн нүд рүү нүүж тоглоно.

Бүлэг дотроо хэн эхэлж тоглохоо шийдээд ээлжлэн тоглоно.

Эхний тоглогч шоогоо орхиод (бүлгүүд өөрсдөө өөр арга ашиглаж болно) буусан шооны нүхний тоогоор нүд дамжин урагш нүүнэ.

Идэвхжүүлэгч тоглогчийн буусан нүүдлийн зурагтай ижил зургийг олон зурагнууд дундаас сугалж аваад тохирох асуултыг уншина.

Тоглогч дараах хариултуудыг өгнө. Үүнд:

- 5Б-ийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний үнэ, бүтээгдэхүүний идэвхжүүлэлт, байршил дөрвийн хувьд оролцогчдын хэлэх хариулт нь “тийм” эсвэл “үгүй” байна. Идэвхжүүлэгч зөв хариултыг шалгана. Хэрвээ бүлгийнхэн уг асуудлыг цааш улам гүнзгийрүүлэн хэлэлцэхийг хүсвэл болох ба үүний дараа дараагийн хүн шоогоо орхино;
- Хэрвээ тоглогчийн чулуу хүний дүрстэй нүдэн дээр буувал идэвхжүүлэгч асуултыг чангаар уншиж тоглогчид боломжит хариултуудаа хэлнэ. Дараа нь бүлгээрээ хамтран хариултуудаа хэлэлцэж нэгдсэн нэг санаа гаргана. Хэлэлцүүлэг дууссан тохиолдолд дараагийн хүн шоогоо орхино;
- Ихэнх бүлгүүд тоглож дууссан бол бусад бүлгүүдээ тоглож дуусахад нь тусална.

III үе (15 минут)

Өөр өөр бүлгийн оролцогчдын дунд туршлага солилцох боломж олгоно. Жишээ нь тэд шинэ зүйл сурч чадсан уу?, Тоглоомыг тоглоход амархан байсан уу, хэцүү байсан уу? Тоглоомоос олж мэдсэн гол зүйл юу вэ? Тэд хариултыг зөвшөөрсөн үү? Хэрвээ үгүй бол яагаад? Тэдэнд улам гүнзгийрүүлэн судлахыг хүссэн асуудлууд байна уу?

¹² С. Бауер, Г.Финнеган, Н. Хаспелс нарын бүтээл, Аж ахуйн нэгжүүдийн эмэгтэй удирдагч нарт зориулсан сургалтын багц болон нөөцийн бүрдэл. ОУХБ, Бангкок: 2004. х. 157-186

Доорх асуултуудыг оролцогчдоос асуух замаар дүгнэлт хийнэ: Танай хоршоонд үүнтэй ижил төстэй асуудал тулгарч байсан уу? Ямар бэрхшээл байсан бэ? Түүнийг хэрхэн шийдвэрлэсэн бэ? Амжилттай шийдэгдсэн үү? Илүү сайн хийх боломж байсан уу? Маркетингийн асуудлаа шийдвэрлэхэд чинь энэ тоглоом танд шинэ санаа өгсөн үү? Аль нь өгсөн бэ? Маркетингийн хольц хөлөгт тоглоомоос аль мэдээлэл нь хамгийн чухал санагдсан бэ?.....

Маркетингийн 5Б-н нэгтгэлийн хүснэгт, зурагт хуудас хоёрыг бүх оролцогчдод тарааж өгнө.



Ашиглах материал

- Жижиг бүлэг бүрт 4 ширхэг хөлөгт тоглоом, эсвэл Хавсралт 2-т үзүүлсний дагуу маркетингийн хольцын хөлөгт тоглоомыг самбарын цаасан дээр зурсан зураг;
- Маркетингийн 5Б-н билэгдлийг харуулсан А4 хэмжээтэй багц зурагт хуудас, мөн www.agriculture-my.com соор сайтаас татаж авч болох 5 багц асуулт бүхий картуудыг ханандаа байрлуулах;
- Оролцогчдын тоогоор өнгө өнгийн чулуунууд (эсвэл баллуур дээр өнгө өнгийн цаасны хавчаар хатгаж, эсвэл өнгөөр будаж бие биенээсээ ялгарна);
- 4 ширхэг шоо.



Хугацаа

2 цаг

4.5: Баталгаажуулалтын тогтолцооны давхар тойргийн дасгал ажил



Зорилго


- Төрөл бүрийн баталгаажуулалтын схемийг танин мэдэх, үнэлэх;
- Төрөл бүрийн баталгаажуулалтын схемийн сайн ба муу талыг хэлэлцэх.



Арга зүй

Сургагч багш баталгаажуулалтын чиглэлээр мэргэшсэн 2-3 шинжээчид, эсвэл оролцогчдоос энэ чиглэлийн туршлагатай хүнийг олж тэдгээрт сэдвийн талаар товч танилцуулна. Ерөнхийдөө үзэсгэлэн худалдааны чиглэлээр, чанарын стандартаар мэргэшсэн, органик үржүүлэгч чиглэлээр мэргэшсэн тус бүр нэг хүн байхаар сонгосон байна.

Гадуураа хос тойргоор хүрээлүүлсэн нэг жижиг тойрог үүсгэсэн байдлаар сандлуудыг байрлуулна. Мөн сургагч багшийн хэрэглэх хэд хэдэн илүү сандал байх шаардлагатай.



Сургагч багш шинжээч нарын хамтаар тойргийн голд зогсон хичээлийг нээж энэхүү сэдвийн зорилго арга зүйг танилцуулна. Энэ хичээлийн гол зорилго нь олон төрлийн баталгаажуулалтын схемүүд, тэдгээрийн сайн муу талуудыг хамтдаа нээж таних явдал юм.

Дотор талын тойргийн оролцогч бүр/шинжээч бүр сургагч багшаас 5-10 минутын хугацаа авч баталгаажуулалтын схемийн талаар, хоршоо үүнийг хэрхэн олж авах, түүнд тулгарах сорилтуудын талаар тайлбарлана.

Бүлгийн нийт оролцогчдод 3 өөр бодит жишээний талаар танилцуулсны дараа Давхар тойргийн хэлэлцүүлгийг албан ёсоор нээнэ. Санал хэлэх болох асуулт тавихыг оролцогчид хүсвэл дотор талын тойрогт байгаа хоосон сандал руу шилжин сууж болно. Хэрэв тэнд хоосон сандал байхгүй бол дотор

талын тойргийн нэг оролцогч сайн дураараа сандлаа чөлөөлөх хэрэгтэй. Оролцогчид дотор тойрог руу орох, гарах зэргээр ойр ойрхон өөрчлөгдөж хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ. Оролцогчид дотор талын тойрог руу хэдэн ч удаа орох боломжтой байна.

Гадна тойргийн оролцогчид ажиглагчийн үүргээр байнга чимээгүй байх ёстой. Сургагч багш энэ зарчмыг хатуу баримтална. Гадна тойргийнхон санал, асуулт бэлтгэж бэлэн болсон үедээ дотор тойрог руу шилжинэ.



Зөвлөгөө

- Хэлэлцүүлгийг дүгнэж тухайн яригдсан сэдвийн дагуу эсвэл хангалттай цаг байвал үлдсэн сэдвийн талаар ярилцахаар оролцогчдыг урих;
- Дотор тойргийн сандлуудыг холдуулснаар нэгдсэн дүгнэлт хэлэлцүүлэгт оролцоог жигд хангах боломж бүрдүүлэх;
- Дүгнэлтийн үед тодорхой асуудлуудын талаарх бүлгийн хандлага, гол санаа, сонирхолтой санал зэргийг давтах.



Ашиглах материал

- 2 эгнээ тойрог;
- Хэлэлцүүлэгт ашиглагдах самбарын цаас;
- Дүгнэлт хэлэлцүүлэгт ашиглах самбарын үзэг.



Хугацаа

Давхар тойргийн дасгалын ямар ч төрөлд доод тал нь 1 цаг 30 минут шаардлагатай.

Бүх модулиуд

5.1: Чөлөөт орон зай



Зорилго

ХАА-н хоршоодын удирдлагын талаар өөрсдөө тодорхойлсон асуудлууд ба сорилтуудыг судлах болон туршлага солилцох.

Арга зүй

Чөлөөт орон зай нь олон төрлийн хууль эрх зүй, зарчмуудыг судалдаг учраас маш сайн бүтэц бүхий зохион байгуулалтын журмыг бий болгохоос гадна оролцогчдын чөлөөт байдлыг хангадаг учраас хамгийн үр бүтээлтэй, бүтээмжтэй арга юм.

Оролцогчдын хувийн зохион байгуулалт, бүтээлч байдал нь дараах зүйлсийг агуулна.

БУСАДТАЙГАА ХОЛБОГДОХ: Бид бүхэн энд цуглаад байгаагийн гол шалтгаан нь энэхүү сэдэв(ХАА-н хоршоодийн менежмент)-ээр суралцах бодит хүсэл бидэнд байгаа бөгөөд мөн үүнийг судлах, энэ талаар төлөвлөх, үйл ажиллагаа явуулах хүсэл эрмэлзэлтэй хүмүүстэй холбогдох цорын ганц боломж юм.

АНХААРЛАА ТӨВЛӨРҮҮЛЭХ: Өндөр түвшний гүйцэтгэл болон үр дүнтэй зохион байгуулалт хийхэд саад болох, бүтцийн явцад яг юу болох талаар бид урьдчилан мэдэж чадахгүй. Иймд оролцогчид биднээс хамаагүй илүү үр дүнтэй арга замаар оролцдог. Сургагч багш оролцогчдын голд зогсоод хоосон цаасан дээр бүтэцчилэгдсэн үйл явцыг оролцогчдоор маш хурднаар бөглүүлэх бөгөөд энэ нь өнөөдрийн хичээлийн сэдэв болохыг тайлбарлаж өгнө.

ХУВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ҮЙЛДЭЛ: “Манай хоршоо” сэдэвтэй холбоотой хэрэгтэй санаа, төвөгтэй асуудлууд, урган гарах асуултуудыг хүссэн хүн болгон тавьж болно. Ингээд оролцогчид хувь нэмрээ оруулах, эсвэл суралцах зорилгоор байнга өөрөө өөрсдийгөө удирдана. Энэ нь бүхэлдээ сургалтын үр өгөөжийг оновчтой болгох үйл явц юм.

ҮР ДҮН: Сургалтыг зохион байгуулагчид тэмдэглэл хөтлөх үүрэг хүлээж, тэмдэглэлээ компьютер болон бусад хэрэгсэл дээр бичиж хадгална.

Хэрэгжүүлэх ve шат:

Сандалуудыг тойрог хэлбэрээр байрлуулж, хэлэлцүүлэгт зориулан хоосон цаас бэлдэнэ. Цавуутай том цаас ашиглаж, хэлэлцүүлгээс гарах саналуудыг эмх цэгцтэй бичнэ.

Сэдэв болон зорилгыг танилцуулсны дараа хэлэлцэх асуудлыг бичүүлэхийн тулд оролцогчдыг дотор талын тойрогт урина.

Оролцогчдыг хэлэлцэх асуудлууд дээр өөрсдийнхөө саналыг танилцуулж өөрийн нэрийн хамт бичих заавар өгнө.

Давхардсан санал гаргахаас сэргийлж оролцогчдыг нэг асуудал дээр нэг санал гаргахыг анхааруулна.

Хичээлийг эхлүүлэхийн өмнө хамгийн сэргэлэн эсвэл туршлагатай оролцогчыг сонгож хэлэлцүүлгийн сэдэв бүр дээр тэмдэглэл хөтлүүлнэ.

Тухайн нэг сэдэвт хэд хэдэн хүн оролцох сонирхолтой байгаа бол сэдвийг нэгтгэж эсвэл зэрэгцүүлэн зохион байгуулж болно.

Оролцогч сургалтын явцыг бичиж тэмдэглэх шаардлагатай үед л зөвхөн сургагч багш туслалцаа үзүүлж чиглүүлэх ба бусад тохилдолд үүнд оролцох шаардлагагүй.

Оролцогчид “Хоёр хөлийн хууль” буюу “өөрийн үүргийг ухамсарлаж хариуцлагаа мэдрэх хууль”-ийг сайн ойлгосныг нягтлах хэрэгтэй. Хэрвээ ямар ч үед оролцогч нь суралцах, хувь нэмрээ оруулах талаар ойлголтгүй байвал “Хоёр хөлийн хууль”-ийг дараагийн сургалтанд оролцохдоо ашиглах ёстой.

Оролцогчид нэгэн зэрэг төлөвлөгдсөн хоёр хичээлд оролцохыг хүсвэл зөрчилдөөн үүснэ. Цагийн хуваариа мэдсэн оролцогч 2 зохион байгуулагчыг олж, хичээлийг нь нэгтгэх эсвэл цагийг нь өөрчлөхийг хүсэлт тавих ёстой. Энэ оролдлого нь амжилтгүй болвол оролцогч нь хоёр бүлгийн хооронд ээлжлэн оролцож болно.

Хичээл бүрийн төгсгөлд сурах үйл явцын тайланг бэлдэх цаг гаргаж өгөх ёстой. Энэ нь гарсан гол санаа, хэлэлцүүлгийн үр дүн, оролцогчдын нэрсийн жагсаалт, чиглүүлэгчийн нэр, сэдвийн гарчиг, хугацаа зэргийг багтаасан жигд загвараар хангахад чиглүүлэгчид тусалдаг.

Дугуй ширээний ярилцлагаас гарсан үр дүн болон гол асуудлуудыг хэлэлцэхийн тулд хичээл дуусахаас нэг цагийн өмнө оролцогчдод цагийг сануулна.

Сургагч багш “Чөлөөт орон зай” сургалт зохион байгуулсны дараа эцсийн тайлан бэлдэхэд зориулж анхан шатны тайлангуудыг жишээ болгон хичээл бүрээс авна гэдгийг мэдэгдэх ёстой.

ЧӨЛӨӨТ ОРОН ЗАЙ

ХАА-н хоршооны удирдлагаар өөрөө шинээр олж тодорхойлсон асуудал болон сорилтууд

Сэдэв:

- 09:00 Нээлт болон чөлөөт орон зайны тухай танилцуулга
- 09:30 Жижиг бүлгийн хэлэлцүүлэгт зориулсан сэдвүүдийг сонгох
- 10:00 Жижиг бүлгийн хэлэлцүүлэг 1
- 11:00 Жижиг бүлгийн хэлэлцүүлэг 2
- 12:00 Хаалтын тойрог
- 14:00 Жижиг бүлгийн хэлэлцүүлэг 3
- 15:00 Жижиг бүлгийн хэлэлцүүлэг 4
- 16:00 Хаалтын тойрог
- 16:30 Дүгнэлт хэлэлцүүлэг

Чөлөөт орон зайн зарчмууд

1. Оролцохоор ирсэн хүн болгон зөв хүн байдаг.
2. Хэзээ эхэлнэ, тэр нь хамгийн тохиромжтой цаг байх болно.

3. Юу ч тохиолдсон энэ нь тохиолдох цорын ганц зүйл байна.

4. Энэ хэзээ дуусна тэр үед л дуусдаг.

5. Хоёр хөлийн хууль

Та өөрийгөө сайтар судлаагүй болон хувь нэмрээ оруулж чадаагүй нөхцөлд орсон гэж бодож байгаа бол чаддаг хаа нэг газар руу яв.

5.2: Туршлага судлах аялал



Зорилго

Сургалтаар олж авсан мэдлэг, чадвар, хандлагаа бодит нөхцөл байдал дээр давтах явдал юм. Туршлага судлах аялал нь “Манай хоршоо” сургалтын багцыг улам үнэ цэнэтэй болгодог бөгөөд таньд бодит байдлаас сурах боломж олгодог.



Туршлага судлах аяллын зөвлөгөө

Туршлага судлах аяллын хөтөлбөр болон зарчмыг тайлбарлаж, тэдгээрийг “Манай хоршоо” модулиудийн тодорхой нэг хэсгүүдтэй холбож өгнө. Оролцогчдод би юу сурсан бэ? Сурснаа би өөрийн ажил мэргэжилд хэрхэн хэрэглэж чадах вэ? зэрэг чиглүүлэгч асуултанд хариулна. Мөн өөрсдийн туршлагыг бичиж тэмдэглэх тэмдэглэлийн дэвтэр тарааж өгнө.

Туршлага судлах аяллын хамгийн чухал асуудлуудын талаар хэлэлцэхээр хоршоотой албан бус уулзалтыг урьдчилан зохион байгуулна. Ингэснээр хоршоо хамгийн тохиромжтой байдлаар бэлтгэнэ. Нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгуулж юу нээж илрүүлсэн, ойлгосон талаар хамтарсан дүгнэлт хийж болно.

5.3: “ХАА-н хоршоодыг удирдах нь” сургалтыг үнэлэх дасгал



Зорилго

- Сургалтын явцад олж авсан мэдлэг, чадвар, хандлагыг сэргээн санах;
- Мэдлэг болон мэдээллээ бататгах.



Арга зүй

Оролцогчид өөрсдөө санамсаргүй байдлаар 3 дэд бүлэгт хуваагдана. Бүлгүүд нэг ба хоёр дахь өдрийн хичээлүүдийг сэргээн давтаж, бусад бүлгүүдэд зориулж сорилт болохуйц 5 асуултыг жагсаан бичнэ (Асуултууд нь нэгдсэн хэлэлцүүлгийн явцад гарсан аль ч сэдвийг хамарсан байж болно). Асуултууд нь ойлгомжтой байх ба самбарын цаасан дээр бичигдсэн байна.

Бусад 2 бүлгийг асуултанд хариулахыг урина. Асуултаа бичсэн баг нь хариултаа бэлтгэж нэмэлт мэдээллээр хангана.

Дэд бүлгүүдийн хоорондын тэмцээн: хариулт авч чадаагүй олон асуулттай үлдсэн баг нь ялагч болно.



Ашиглах материал

- 3 самбарын цаас;
- 3 самбарын үзэг;
- Ялсан бүлэгт өгөх шагнал.



Хугацаа

30-45 минут

Bauer S.; Finnegan G.; Haspels N. 2004. GET ***Ahead for Women in Enterprise Training Package and Resource Kit*** (Bangkok, ILO).

ILO Promotion of Cooperatives Recommendation, 2002 (R193).

ILO/COOPAFRICA. 2010. Project design manual: ***A step-by-step tool to support the development of cooperatives and other forms of self-help organizations*** (Geneva, ILO).


ХАВСРАЛТ I


Сургалтын хөтөлбөрийн загвар

Хугацаа	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
09:00-10:30	Сургалтын танилцуулга ба нээлт	Өртгийн сүлжээний дасгал ажил	ХАА-н үйлдвэрлэлийн орцыг нийлүүлэхэд тулгарах тодорхой сорилтуудыг шийдвэрлэхэд бие биедээ туслах аргыг ашиглах нь	Өртгийн сүлжээний бодит жишээ	"Чөлөөт орон зай" эсвэл Туршлага судлах аялал
	Оролцогчдыг танилцуулах	Засаглалын сорилтууд		Хоршооны үйл ажиллагааг сайжруулах.	ХАА-н хоршооны удирдлагаар өөрөө шинээр олж тодорхойлсон аргачлал
	Хоршооллын шоо	Оюуны бичиглэлийн дасгал ажил		Шилдэг 100 жагсаалт	
	Хоршооны тухай үндсэн ойлголт ба зарчим				
10:30-11:00	Цайны завсарлага	Цайны завсарлага	Цайны завсарлага	Цайны завсарлага	Цайны завсарлага
11:00-12:30	Хоршооны мэдлэгийн өртөө	Хэрэгцээг тодорхойлох	Агуулах ба нөөцийн агуулахын удирдлагын "Өртөөчилсэн аялал" дасгал ажил	Зах зээлийн мэдээллийн шинжилгээ	
	Хоршооны гишүүн байх нь	Ялгаатай арга хэрэгслүүдийн эвлүүлгийн дасгал ажил		Туршлагад суурилсан сургалт	"Чөлөөт орон зай"
12:30-14:00					
14:00-15:15	Хоршоогоо төвч танилцуулья	Оюуны зураглал ба хэрэгцээг эрэмбэлж үйлчилгээтэй холбох дасгал ажил	Үнийн бодлого боловсруулах Шинжээч нарын мэтгэлцээний арга	Маркетингийн холыцын хөлөгт тоглоом	
	Бодит түүх ярих дасгал ажил	Өөрсдийн бодлоо зургаар илэрхийлэх		Тоглоомд суурилсан сургалт	"Чөлөөт орон зай"
15:15-15:45	Цайны завсарлага	Цайны завсарлага	Цайны завсарлага	Цайны завсарлага	Цайны завсарлага
15:45-17:00	Хоршооны орчин	Хоршооны гишүүддээ үзүүлэх үйлчилгээний дотоод нөөц боломжийн талаарх нөхцөл байдлын шинжилгээ		Баталгаажуулалтын тогтолцоон дахь Давхар тойргийн дасгал	"Чөлөөт орон зай" дасгал ажил, туршлага судлах аялалын дүгнэлт
	Хамтын ажиллагааны шинжилгээ				Сургалтын үнэлгээ ба хаалтын ажиллагаа


ХАВСРАЛТ II

Маркетингийн хольцын хөлөгт тоглоом





Маркетингийн “5Б”-ийн нэгтгэл



Бүтээгдэхүүн




Бүтээгдэхүүний үнэ



Байршил



Бүтээгдэхүүний идэвхжүүлэлт



Бүтээгдэхүүнд оролцогч

www.agriculture-my.coop